



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2017 он



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

“Оюуны Инноваци” ТТБ-ын судлаачид Ажиглалтын үр дүнг боловсруулж,
энэхүү тайлаг бичив.

Судлаачид: П.Баттулга
Ж.Батмөнх
М.Мөнхжаргал
Б.Төрболд
Б.Эрхэмбаяр

Хянан тохиолдуулсан: П.Бадамрагчаа, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

© Нээлттэй Нийгэм Форум

Уг тайланг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэж, олшруулахыг хүсвэл
дараах хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ННА 67
ДАА 340
Ш-978

ISBN: 978-99978-803-1-4

ГАРЧИГ

Өмнөх үг	4
Удиртгал	5
А. ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ	7
Нэг. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын хэрэгжилт	7
Хоёр. Бие даасан, хараат бус, шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилт	9
Гурав. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчмын хэрэгжилт	11
Дөрөв. Гэм буруугүйд тооцогдох болон дуугүй байх эрхийн хэрэгжилт	15
Тав. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулалгүй шүүлгэх эрхийн хэрэгжилт	21
Зургаа. Өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт	28
Долоо. Орчуулагч, хэлмэрч авах эрхийн хэрэгжилт	31
Найм. Нотлох баримт гаргах, үнэлүүлэх эрхийн хэрэгжилт	32
Ес. Шүүхийн шийдвэр	34
Б. ШҮҮХ ХУРАЛДААНЫ ЗАРИМ СУБЪЕКТҮҮДИЙН ОРОЛЦОО	36
Нэг. Хохирогч	36
Хоёр. Шүүхийн иргэдийн төлөөлөгч	37
Гурав. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга	38
Дөрөв. Шүүхийн хуяг	39
В. ШҮҮГЧ, ШҮҮХИЙН АЖИЛТНУУДЫН ХАРИЛЦААНЫ БАЙДАЛ	41
Г. ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДЭГ ХАНГАГДАЖ БУЙ БАЙДАЛ	42
Д. ШҮҮХИЙН БАЙРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	44
Нэг. Шүүхийн байрны тохижилт болон хүндэтгэл төрүүлэхүйц байдал	44
Хоёр. Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал	45
ДҮГНЭЛТ	46
Е. ХАВСРАЛТ	48
Шүүх хуралдааны ажиглалтын хуудас	48
Шүүхийн ажиглагчид	59

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форум 2008 оноос эхлэн хэрэгжүүлсэн Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийнхөө хүрээнд иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-уудын зүгээс шүүхийн нээлттэй байдал, иргэдийн шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтэд хөндлөнгийн мониторинг хийхэд дэмжлэг үзүүлж ирлээ. Ийнхүү ИНБ-ууд 2010 онд анх удаа шүүхийн шинэтгэлийн үйл явцын хэрэгжилтэд ажиглалт хийж байсан бол 2014 онд шүүхийн үйл ажиллагааг шүүхийн тухай багц хууль батлагдахаас өмнөх үетэй харьцуулан шинжилсэн юм.

Энэ удаад шүүхийн ажиглалтын арга зүй эзэмшсэн орон нутгийн ИНБ-ууд эрүүгийн хэргийн анхан шатны 10 шүүхэд ажиглалт хийж, орон нутгийг өргөн хамрах болсноороо онцлог боллоо. Түүнчлэн өмнө нь хийгдэж байсан шүүхийн ажиглалтын үр дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхийг зорилоо.

Шүүхийн ажиглалтын дүнг нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх ажлыг эрх зүйн судалгааны байгууллагын судлаачид гүйцэтгэсэн нь орон нутгийн ИНБ-ууд судалгааны байгууллагуудтай хамтран судалгааны болон бусад төслийг өргөн хүрээнд

үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжтойг харууллаа. Цаашид орон нутагт бий болсон энэхүү чадавхад үндэслэн шүүхийн мониторинг, ажиглалт, судалгааг өргөн хүрээнд тогтмол хийж, цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг шүүхийн шинэтгэлийн үйл явцад тусган хэрэгжүүлэхэд шүүх, шүүхийн захиргааны болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд анхааран ажиллана гэдэгт найдаж байна.

Шүүхийн ажиглалтын төслийг амжилттай хэрэгжүүлсэн 10 аймгийн нэр бүхий төрийн бус байгууллагын ажилтнууд, дүн шинжилгээ хийж зөвлөмж боловсруулах ажлыг хариуцан гүйцэтгэсэн Оюуны Инноваци ТББ-ын судлаачдад ННФ-ын өмнөөс талархал илэрхийлье.

Энэхүү тайланг сонирхон үзэх эрхэм Та бүхэн ажиглалтын дүн, дүгнэлт, санал, зөвлөмжийг анхааралтай авч үзэж, шударга, хараат бус, нээлттэй шүүхийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

ҮДИРТГАЛ


Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажсан шударгаар шүүлгэх эрхийн стандартыг шүүхийн практикт хэрхэн хэрэгжүүлж байгаад тогтмол ажиглалт явуулж, дүн шинжилгээ хийх нь учирч буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Нээлттэй Нийгэм Форум (ННФ) 2010, 2015 онуудад шүүхийн ажиглалт явуулж, ажиглалтын дүнг салбарын ажилтнууд болон энэ чиглэлээр суралцаж буй оюутнуудад хүргэсний зэрэгцээ мөн олон нийтэд нээлттэй түгээсэн билээ. 2017 оны хувьд орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор ээлжит шүүхийн ажиглалтыг Булган,

Дархан, Дорнод, Завхан, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий, Увс зэрэг арван аймаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаануудад 2017 оны 5 дугаар сарын 8-наас 6 дугаар сарын 30-ны хооронд 8 долоо хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Ажиглалтын хугацаанд сонгон авсан нийт 330 шүүх хуралдаанаас 125 нь хойшлогдож нийт сонгосон шүүх хуралдааны 62 хувьд нь буюу 205 шүүх хуралдаанд бүрэн үнэлгээ хийлээ. Үүнээс бүрэн бөглөгдөөгүй асуулгын хуудас болон асуултыг хасан тооцож дүн шинжилгээ хийсэн болно. Доорх графикт сонгосон 10 аймаг тус бүрт хэдэн шүүх хурал ажигласныг харуулав (График 1).

График 1. Ажиглалт хийсэн шүүх хуралдааны тоо



Шүүхийн ажиглалтад Ажиглагч нарын үүрэг нэн чухал бөгөөд хуульч бус энгийн иргэдийн ажиглалт, дүгнэлтээр шүүхийн үйл ажиллагааг дүгнэх нь нийт иргэдийн хувьд шүүхийг ямар дүр төрхтэйгээр харж ойлгож байгааг илэрхийлэхэд дөхөмтэй гэж үздэг байна. Иймд ННФ 2015 оноос эхлэн нийт 20 аймгийн иргэний нийгмийн байгууллагуудад бүсчилсэн сургалт явуулж шүүхийн ажиглалтын арга зүйг танилцуулаад байгаа бөгөөд энэ удаагийн шүүхийн ажиглалтын төсөл нь эдгээр орон нутгийн

иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, идэвх санаачилгад үндэслэн хэрэгжсэн юм. Ажиглалт хийсэн баг тус бүр 3-4 гишүүнтэй ажилласан бөгөөд өөрсдийн оршин суугаа аймгийн шүүхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанд дээр дурдсан хугацаанд нэгэн зэрэг ажиглалт хийж анхан шатны мэдээлэл цуглууллаа. Харин ажиглалтын дүнд Оюуны Инноваци ТББ-ын хуульч, судлаачдын баг дүн шинжилгээ хийн боловсруулж гаргасныг Танд энэхүү товхимлоор толилуулж байна.

А

ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

НЭГ.

Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын хэрэгжилт

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байж, хуулиар ямар ч алагчлалгүйгээр адилхан хамгаалуулах эрхтэй болохыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан байдаг билээ. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх энэхүү зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” хэмээн баталгаажуулсан.

Түүнчлэн 2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Монгол

Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” хэмээн заасан бол 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлээд байгаа шинэчлэн батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлийн 1-д дээрх заалтыг улам бүр өргөжүүлж “Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын


хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заажээ.

Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим нь иргэдээс эхлэн төрийн байгууллага, албан тушаалтан зэрэг бүх хүнд хамааралтай, тэдэнд үйлчлэх ёстой. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга явагдах гол нөхцөл нь шүүгчийн зүгээс аль нэг оролцогчийн талд давуу байдал олгохгүй байх буюу талуудад тэгш боломж олгох явдал юм. Нийт ажиглалт явуулсан шүүх хуралдааны 99 хувьд нь шүүгч хуралдааны үеэр оролцогчдын аль нэг талд давуу байдал олгоогүй нь харагдсан. Мөн улсын яллагч, өмгөөлөгч нарын шүүх хурлын оролцоо харьцангуй тэгш эрхтэй байгаа нь ажиглагджээ.

Нийт ажиглалт явуулсан шүүх хуралдааны 92 хувьд нь улсын яллагч болон өмгөөлөгч нар шүүх хуралдаанд тэгш эрхтэй оролцсон байна. Харин шүүгдэгч өмгөөлөгч аваагүй, шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй нэг тохиолдлыг

ажиглагч нар талууд шүүх хуралдаанд тэгш эрхтэй оролцож чадаагүй гэж үзсэн байна.

График 2. Шүүх хуралдаанд улсын яллагч, өмгөөлөгч нар эрх тэгш оролцсон эсэх



Шүүхийн хэлэлцүүлгийн үед улсын яллагч яллах дүгнэлтээ өөрчлөх санал гаргах нь онцгой тохиолдолд тооцогддог. Ажиглалт хийсэн нийт хэргийн 7 хувьд нь улсын яллагч яллах дүгнэлтээ өөрчилсөн нь 2015 онд хийсэн судалгаатай харьцуулахад өндөр үзүүлэлттэй гарсан байна. Үүнийг Хүснэгт 1-д тоон үзүүлэлтээр харуулав.

Өмгөөлөгчийн хувьд өөрийн өмгөөлж байгаа хүнийхээ эрх, хууль

Хүснэгт 1. Талуудын тэгш байдал 2015 оны судалгаатай хийсэн харьцуулалт

Үзүүлэлт	2015 он	2017 он
Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд улсын яллагчийн зүгээс ялын дүгнэлтийг өөрчлөх санал гаргасан	1,1%	7%
Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд өмгөөлөгчийн зүгээс ялын асуудлаар санал гаргасан	68,8%	70%
Талуудад хэлэлцүүлгийн шатанд үг хэлэхийг зөвшөөрсөн		99%
Шүүгч шүүгдэгчийг эцсийн үгээ хэлэхэд нь саад хийсэн	5,4%	3%

ёсны ашиг сонирхлыг хамгаалах нэг чухал ажиллагаа нь ялын талаар тодорхой санал гаргаж, яллах талтай мэтгэлцэх явдал байдаг. Судалгаанд хамрагдсан нийт хэргийн 30 хувьд нь өмгөөлөгчийн зүгээс шүүгдэгчид оногдуулах ялын талаар тодорхой санал гаргаагүй байна. 2015 онд судалгаанд хамрагдсан хэргийн 31.2 хувьд нь өмгөөлөгч ялын талаар санал гаргаагүй гэсэн үр дүнтэй харьцуулахад бага зэрэг буурсан үзүүлэлт боловч үүнийг үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй өмгөөлөгчийн мэргэжил, ур чадварын үүднээс авч үзвэл анхаарал татсан сөрөг үзүүлэлт юм.

Шүүх хуралдаанд оролцогчдын эрхийг хангах үүднээс шүүх хуульд заасан журмын дагуу оролцогчдод үг хэлэх боломж олгох ёстой. Энэ удаагийн ажиглалтаар шүүхээс талуудад үг хэлэх боломжийг адил тэгш олгож байгаа нь харагдлаа. Харин шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орж шийдвэр гаргахын өмнө шүүгдэгчийн эцсийн үгийг заавал сонсох, шүүгдэгчийн эцсийн үгийг цагаар хязгаарлах ёсгүй боловч судалгаанд хамрагдсан хэргийн 3 хувьд нь шүүгдэгчийн эцсийн үгээ хэлэхэд нь ямар нэгэн байдлаар саад хийсэн байна. Гэсэн хэдий ч энэ үзүүлэлт 2015 онд хийсэн судалгааны дүнтэй харьцуулахад бага зэрэг буурчээ.

ХОЁР.

Бие даасан, хараат бус, шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилт


“Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангана гэдэг нь төрийн бусад эрх мэдэл (хууль тогтоох, гүйцэтгэх)-ээс шүүх эрх мэдлийг бүрэн тусгаарлаж, **шүүгч чиг үүргээ зөвхөн хуульд нийцүүлэн чөлөөтэй, айдасгүй, мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх хууль зүйн болон хувийн баталгааг бүрдүүлэх**”¹ -ийг хэлэх бөгөөд энэ нь шүүхээр хэрэг маргаанаа шийдүүлж байгаа иргэн, хуулийн этгээд “...шударга шүүхээр шүүлгэх...”

үндсэн эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж чадах юм. Энэ зарчмын эрх зүйн үндсийг Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана” хэмээн баталгаажуулсан.

Тийм учраас шударга шүүхээр хэргээ шүүлгэх эрх нь шүүгч тухайн хэргийг шийдвэрлэхийн өмнө ямар нэгэн дүгнэлт гаргах буюу хөндлөнгийн сонирхолгүй байхыг шаарддаг. Шүүгч бусдаас хараат бус байх нь шударгаар шүүлгэх эрх хангагдахад шийдвэрлэх нөхцөл

1 Н.Лүндэндорж “Төрийн онол” УБ., 2008, 228 дахь тал

График 3. Шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах эрхийг тайлбарласан эсэх



болохоос гадна шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байх нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гаргах урьдчилсан нөхцөл болно.

Иймд иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхээ эдлэхийн тулд шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах эсэх талаар хуулийн дагуу хүсэлт гаргах боломжоор хангагдсан байх ёстой. Энэ эрх хэрхэн хангагдаж байгаад мөн ажиглалт хийсэн юм.

Ажиглалтын дүнгээс үзэхэд хуралдаан даргалагч нийт хуралдааны 95 хувьд нь шүүх бүрэлдэхүүнийг

татгалзан гаргаж болох тухай тайлбарласан бол 5 хувьд нь энэ эрхийг тодорхой тайлбарлаж өгөөгүй дүн гарчээ. Ажиглалтын дүнг 2015 онтой харьцуулахад татгалзан гаргах эрхийг сайтар тайлбарлахгүй байгаа тохиолдол өмнөхөөс 2 хувиар өссөн байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Түүнчлэн шүүгч хараат бусаар талуудын тэгш байдлыг хангаж ажилласан байдлыг үнэлэх зорилгоор ажиглалтын үеэр дараах асуултуудын дагуу тэмдэглэл хөтөлж, статистик дүнг боловсруулан Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Шүүгч хараат бус, тэгш байдлыг хангаж ажилласан байдал

Үзүүлэлт	2015 он	2017 он
Шүүгч шүүх хуралдааны оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлаж өгсөн үү?	Тийм /97% /	Тийм /99.1% /
Шүүгч хэргийг алагчлалгүй шийдвэрлэсэн эсэхэд эргэлзээ төрсөн үү?	Үгүй /86.6% /	Үгүй /99.5% /
Шүүгч шүүх хуралдааныг хурдан дуусгахаар хичээж байсан уу?	Үгүй /96.8% /	Үгүй /99.6% /
Шүүгч хэлэлцүүлгийн үеэр шүүх хуралдааны танхимыг түр орхин гарсан уу?		Үгүй /98% /
Шүүгчийн анхаарал төвлөрөл сайн байсан уу?	-	Тийм /98% /
Шүүгчид зөвлөлдөх тасалгаанд шийдвэр гаргах үед зөвлөлдөх тасалгаанд өөр хүн орсон уу?	-	Үгүй /100% /

Шүүгч шүүх хуралдаанд оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой тайлбарлах, хэргийг алагчлалгүй, шударгаар шийдвэрлэхэд эргэлзээ төрсөн байдал, мөн шүүх хуралдааныг дуусгахаар хичээж байсан тохиолдол 2015 онтой харьцуулахад буурсан буюу

эерэг үзүүлэлттэй гарсан байна. Шүүгч шүүх хуралдааны хэлэлцүүлгийн үеэр шүүх хуралдааны танхимыг түр орхин гарсан тохиолдол нэг, шүүгчийн анхаарал төвлөрөл сайн байгаагүй /нойрмоглосон/ тохиолдол мөн нэг удаа гарчээ.

ГУРАВ.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчмын хэрэгжилт

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах нь шүүхийн бие даасан, шударга байх нэгэн чухал үзүүлэлт бөгөөд шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бататгах хамгаалалт болдог.² Тухайн хэргийн онцлогоос шалтгаалан насанд хүрээгүй шүүгдэгчид холбогдох гэх мэт хуулиар хаалттай явуулахыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд шүүх хуралдаан нээлттэй явагдах ёстой. Тиймээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах болон насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэхээс бусад тохиолдолд шүүх хуралдааныг нээлттэй явуулна гэж заажээ.

Нээлттэй шүүх хуралдаанд ажиглагчаар оролцохыг хүссэн иргэн бүрийг ямар нэгэн зөвшөөрөл шаардахгүйгээр шүүх хуралдаанд оролцуулах, ингэхдээ шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах үүднээс зөвхөн бичиг баримт, шаардлагатай тохиолдолд биедээ авч яваа эд зүйлийг шалгаж нэвтрүүлэх учиртай.

Ажиглалт хийсэн эрүүгийн хэргийн нийт шүүх хуралдаанаас үзэхэд шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим бүрэн хэрэгжиж байна гэж дүгнэх боломжгүй байгаа юм (График 4, Хүснэгт 3.)

2 Нээлттэй Нийгэм Форум “Шүүх хуралдааны ажиглалт” Судалгааны нэгдсэн тайлан, Н.Туяа нар, УБ., 2015, 14 дэх тал

График 4. Шүүх хуралдааны танхимд нэвтэрсэн байдал



Хүснэгт 3. Шүүх хуралдааны танхимд нэвтэрсэн байдал

Шүүх хуралдааны танхимд нэвтэрсэн байдал	Саадгүй	76.6%
	Биеийн байцаалт шалгасан	22.7%
	Татгалзсан	0.7%

Ажиглалтын дүнгээс харахад 76.6 хувьд нь ажиглагчдыг шүүх хуралдааны танхимд саадгүй нэвтрүүлж, 22.7 хувьд нь биеийн байцаалтыг шалган оруулж, 2 шүүх хуралдаан буюу 0.7 хувьд нь ажиглагчдыг оруулахаас татгалзсан байна. Аймгуудаар нь авч үзвэл Дархан, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Хөвсгөл, Хэнтий

аймгуудын эрүүгийн хэргийн шүүх бүх хуралдаанд ажиглагчдыг ямар нэгэн саадгүй буюу биеийн байцаалтыг нь шалган нэвтрүүлсэн бол Булган аймагт 2 тохиолдолд ажиглагчийг албан ёсны зөвшөөрөлгүй гэсэн шалтгаанаар шүүх хуралдааны танхимд нэвтрүүлээгүй байна.

Хүснэгт 4. Бусад иргэд шүүх хуралдааны танхимд нэвтэрсэн байдал

Үзүүлэлт	2010 он	2015 он	2017 он
Нээлттэй шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй хүн бүхнийг оруулсан	92.2%	91.2%	98%
Нээлттэй шүүх хуралдаанд оролцоход зөвшөөрөл авсан	66.2%	23.3%	26%


2017 онд нээлттэй шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй хүн бүрийг саадгүй оролцуулсан байдал нь 2015 оныхоос 6.8 хувиар өссөн бол харин зөвшөөрөл авч оролцсон байдал нь 2015 оныхоос 2.7 хувиар өссөн дүн гарчээ. Нээлттэй шүүх хуралдаанд оролцох нийт зөвшөөрлийн 1.4 хувийг шүүгчээс, 1.4 хувийг шүүхийн захиргааны бусад ажилтнаас, 1.4 хувийг шүүгчийн туслахаас, 2.8 хувийг шүүхийн тамгын газрын даргаас, 11.3 хувийг шүүх хуралдааны нарийн бичгийн даргаас, 81.7 хувийг шүүхийн хуяг буюу цагдаагаас тус тус авсан байна.

2015 оны судалгаагаар шүүхийн Тамгын газрын даргаас нээлттэй шүүх хуралдаанд оролцох зөвшөөрөл авсан тохиолдол гараагүй бөгөөд энэ удаагийн ажиглалтаар нээлттэй шүүх хуралдаанд оролцоход зөвшөөрөл авсан тохиолдлын 2.8 хувь нь шүүхийн Тамгын газрын даргаас уг

зөвшөөрлийг олгосон байгааг цаашид анхаарах шаардлагатай. Улмаар нээлттэй зарлагдсан шүүх хуралдаанд олон нийт иргэдийн төлөөлөл оролцохтой холбоотой үлгэрчилсэн журам гаргаж нийтэд мэдээлэх нь энэхүү жигд бус практикийг цэгцлэх, иргэдэд ойлгомжтой болгоход ач холбогдолтой юм.

Ажиглалтын явцад нийт 6 шүүх хуралдаан нээлттэй зарлагдсан хэдий ч шүүх хуралдааны оролцогчдын хүсэлтээр ажиглагч нарыг шүүх хуралдаанд оролцуулаагүй байна. Гэсэн хэдий ч энэ нь 2015 онд хийсэн судалгаатай харьцуулахад 2.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна (График 5). Ажиглагчдыг шүүх хуралдаанд оролцуулахгүй байгаа шалтгааныг бүлэглэн Хүснэгт 6-д харуулсан ба аймаг тус бүрээр дэлгэрүүлж Хүснэгт 7-д харуулав.

График 5. Оролцогчдын зүгээс ажиглагчийг нээлттэй шүүх хуралдаанд оролцуулахаас татгалзсан эсэх



Хүснэгт 6. Шүүх хуралдаанд ажиглагчийг оролцуулаагүй шалтгаан

<i>Насан хүрээгүй шүүгдэгчид холбогдох хэргийн шүүх хуралдаан</i>	4
<i>Шүүгчийн туслах болон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар хаалттай явагдах шүүх хуралдаан гэж хэлсэн</i>	1
<i>Шүүгдэгчийн өмгөөлөгч хүсэлт гаргасан</i>	2
<i>Хохирогчийн өмгөөлөгч хүсэлт гаргасан</i>	1
<i>Хохирогч өөрөө хүсэлт гаргасан</i>	1
<i>Хохирогчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд ажиглалт хийх албан ёсны зөвшөөрөл, бичиггүй хүмүүсийг ажиглагчаар суулгахгүй гэсэн. Улмаар шүүхийн Тамгын газрын дарга Нээлттэй Нийгэм Форумын албан бичиг хэрэгтэй гэсэн</i>	2

Хүснэгт 7. Шүүх хуралдаанд ажиглагчийг оролцуулаагүй шалтгаан /аймаг тус бүрээр/

Булган	Шүүх хуралдаан эхлэхэд хохирогчийн өмгөөлөгч “Шүүх хуралдаанд ажиглалт хийнэ гэсэн албан ёсны бичиг байна уу? шүүх хуралдаанд ажиглалт хийж байгаа гээд янз бүрийн хүмүүс суугаад дараа нь оролцогчдын хувийн асуудлыг бусдад ярьдаг асуудал гардаг. Тиймээс шүүх хуралдаанд ажиглагч оролцуулахгүй” гэсэн бөгөөд хуралдаан даргалагч шүүгч “Та бүхэн тэгвэл албан ёсны бичгээ авч ирээд хуралдаанд суугаарай” гэсэн тул бид танхимаас гарсан. Ингээд шүүхийн Тамгын газрын даргатай уулзаж шүүх хуралдаанд ажиглалт хийх албан бичгийг өөрийн байгууллагын нэрийн өмнөөс өгсөн боловч шүүхийн Тамгын газрын дарга “Нэгэнт ийм хэл, ам гараад байгаа учраас албан ёсоор ННФ-ын албан бичиг аваад ир” гэсэн. Ингээд тухайн өдрийн хоёр шүүх хуралдаанд сууж чадаагүй. Гэхдээ дараагийн шүүх хуралдаануудад албан бичиггүйгээр сууж ажиглалтаа хэвийн явуулсан. Насанд хүрээгүй шүүгдэгчид холбогдох нэг шүүх хуралдаан байсан.
Завхан	Хохирогчийн өмгөөлөгч гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг учраас шүүх хуралдаанд ажиглагч оролцуулмааргүй байна гэсэн хүсэлт гаргасан бөгөөд шүүгч хүсэлтийг хүлээж авсан тул танхимаас гарсан.
Орхон	Шүүгчийн туслах болон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ шүүх хуралдаан хаалттай явагдана гэж хэлсэн тул танхимаас гарсан. Шүүгдэгчийн өмгөөлөгч “хувь хүний мэдээлэл яригдах учраас шүүх хуралдаанд ажиглагч суулгахгүй” гэсэн хүсэлт гаргасныг шүүгч хүлээж авсан тул танхимаас гарсан. Насанд хүрээгүй шүүгдэгчид холбогдох нэг шүүх хуралдаан байсан.
Хөвсгөл	Насанд хүрээгүй шүүгдэгчид холбогдох хоёр шүүх хуралдаан байсан.
Өвөрхангай	Шүүх хуралдаан эхлээгүй байсан бөгөөд хохирогч өөрөө “шүүх хуралдаанд битгий суугаач” гэж гуйсан учир хуралдаанд суугаагүй.
Хэнтий	Шүүх бүрэлдэхүүн танхимд орж ирээгүй байсан бөгөөд шүүгдэгчийн өмгөөлөгч нь гэр бүлийн асуудалтай хэрэг болохоор та нарыг ажиглагчаар суулгамааргүй байна гэхээр нь танхимаас гарсан.

Дээрхээс шалтгаан, тайлбаруудаас харахад насанд хүрээгүй шүүгдэгчид холбогдох 4 шүүх хуралдаан, хохирогчийн өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой шүүх хуралдааныг шүүгч хаалттай явуулсан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт зааснаар шүүх хуралдааныг хаалттай явагдах үндэслэлд хамаарч байна. Харин шүүх хуралдаанд ажиглалт хийх албан ёсны бичиг шаардлагатай, хувь хүний мэдээлэл яригдах учраас ажиглагчийг шүүх хуралдаанд оролцуулахгүй гэсэн өмгөөлөгчийн хүсэлтийг шүүх хүлээж авсан нь ямар нэгэн хууль, эрх зүйн тодорхой үндэслэлгүй байгаа юм. Өвөрхангай, Хэнтий аймагт гарсан тохиолдлын хувьд шүүгч болон шүүх хуралдааны оролцогчдын зүгээс ажиглагчийг шүүх хуралдаанд оролцуулахаас татгалзаагүй бөгөөд ажиглагч нар шүүх хуралдааны оролцогчийн хүсэлтийн дагуу сайн дураар шүүх хуралдаанд оролцоогүй байна.

Шүүхийн ажиглагч нарын хувьд шүүхийн хэвийн үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр саад тотгор учруулахаас зайлсхийх буюу болсон үйл явдлыг тэмдэглэн авах л үүрэг хүлээж байсан тул аливаа шаардлага хуульд нийцсэн эсэхээс үл хамааран шаардлагыг биелүүлэн зарчмын дагуу ажилласан гэдгийг энэ дашрамд дурдах нь зүйтэй.

Шүүхүүд шүүх хуралдааны зар гаргахдаа тухайн шүүх хуралдаан нээлттэй эсхүл хаалттай явагдах талаар зард тодорхой тусгадаггүй байна. Мөн шүүх хуралдааны зар өөрчлөгддөг зэрэг шалтгааны улмаас ажиглагч нарт шүүх хуралдаан хаалттай явагдана гэсэн мэдээллийг шүүгчийн туслах болон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга зөвхөн хурал эхлэхийн өмнө өгч байсан нь ажиглалт хийх хурлыг сонгоход, шүүх хуралдаанд бүрэн ажиглалт хийхэд хүндрэл учруулж байв.

ДӨРӨВ.

Гэм буруугүйд тооцогдох болон дуугүй байх эрхийн хэрэгжилт

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 14-т “...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ...Өөрөө өөрийнхөө эсрэг

мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн

гэм буруутайд тооцож үл болно...” гэж зааснаар хүний халдашгүй байх, гэм буруугүйд тооцогдох, шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхийн үзэл санааг баталгаажуулжээ. Улмаар гэм буруугүйд тооцогдох зарчмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “ ..., гэмт хэрэг үйлдсэн этгээд бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангахад оршино” хэмээн Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт болгон хуульчилсан.

Гэм буруугүйд тооцох зарчим нь эрүүгийн хэрэг дээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх үед нэг талыг барих, урьдаас тогтсон хөдөлбөргүй үнэн гэх нотлох баримт шүтэх явдлыг үгүйсгэж, бусдыг үндэслэлгүйгээр яллагдагчаар татах, шүүхэд шилжүүлэх, ял шийтгэл оногдуулахгүй байхын нэг чухал баталгаа мөн.³ Гэм буруугүйд тооцох нь сэжигтэн, яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай эсэхийг мөрдөгч, прокурор болоод бусад субъектүүдийн санаа бодлоор биш, харин хөндлөнгийн, хараат бус шүүх л шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн хэмээн гэм буруутайд тооцон түүнд зохих ял шийтгэлийг оногдуулах

3 Бат-Эрдэнэ Б. “Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй” ерөнхий анги УБ., 2000., 50 дахь тал.

явдал юм. Яллах тал яллагдагчийн гэм бурууг нотлох үүрэгтэй бөгөөд түүний гэм бурууг гарцаагүй байдлаар нотолж чадахгүй бол яллагдагч гэм буруутан болохгүй. Ийнхүү шүүгдэгчийн гэм буруутайг гарцаагүй байдлаар тогтоож чадаагүй бол түүнийг цагаатгах ёстой.⁴

4.1. Гэм бурууг хүчээр хүлээлгэхээс ангид байх эрх

Гэм буруугүйд тооцогдох зарчим, хүний халдашгүй байх эрхийг хангах арга зам нь “хүний эрхэм чанар” /human dignity/ гэх ойлголттой холбогдох бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг доромжлох буюу шүүгдэгчийг ёс суртахууны хувьд илт буруутгаж, дорд үзэж болохгүй. Мөрдөгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгчээс өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглох, эсрэгээрээ гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардаж болохгүй. Ажиглалтаар дээрх асуудлыг тодруулах судалгаа мөн хийгдсэн ба үр дүнг График 6-д харуулав.

4 Нээлттэй Нийгэм Форум “Шүүх хуралдааны ажиглалтын тайлан”, Н.Туяа нар, УБ., 2010, 18 дахь тал.

График 6. Шүүгдэгчийг гэм буруутай мэт сэтгэгдэл төрүүлсэн тохиолдол байсан эсэх



Ажиглалтын дүнгээс үзэхэд шүүгдэгчийг гэм буруутай мэт сэтгэгдэл төрүүлсэн буюу зориудаар үсийг нь хуссан, хоригдлын хувцас өмсүүлсэн эсхүл өөр бусад байдлаар гэм буруутай мэт сэтгэгдэл төрүүлэхээр нөхцөл байдал түгээмэл хэлбэрээр ажиглагдаагүй байна. Харин Увс аймагт 1 удаагийн шүүх хуралдаанд шүүгдэгчийн үсийг нь хуссан байсан нь гэм буруутай мэт сэтгэгдэл төрүүлэхүйц байсан гэж ажиглагч нар тэмдэглэжээ.

Түүнчлэн шүүгдэгчийн “хүний эрхэм чанар”-ыг хөндсөн ямар нэг зүйл шүүх хуралдааны үеэр байсан эсэхийг ажиглахад хэлэлцүүлгийн явцад улсын яллагч шүүгдэгчийн нэр төрийг нь доромжилсон, ёс суртахууны хувьд дорд үзэж, илт буруутгаж харьцсан тохиолдол Орхоноос бусад аймагт гараагүй байна. Харин шүүх хуралдааны хэлэлцүүлгийн үеэр шүүгч шүүгдэгчийн нэр төрийг нь доромжилсон, ёс суртахууны хувьд дорд үзэж, илт буруутгаж харьцсан тохиолдол Орхон аймагт нэг удаа гарсан болохыг ажиглалтын тайланд тэмдэглэжээ (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Шүүгдэгчийг дорд үзэж байсан эсэх талаарх асуултын дүн

Үзүүлэлт	2017 он
Улсын яллагч шүүхийн хэлэлцүүлгийн үеэр шүүгдэгчийг ёс суртахууны хувьд дорд үзэж илт буруутгаж харьцсан	0%
Шүүгч шүүхийн хэлэлцүүлгийн үеэр шүүгдэгчийг ёс суртахууны хувьд дорд үзэж, илт буруутгаж харьцсан	0,5%
Шүүгч шүүгдэгчид гэм бурууг нь хүлээлгэхээр дарамталсан	0,5%

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т “... шүүх нь ...шүүгдэгчийг өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” гэж заасан. Гэтэл шүүх хуралдааны үеэр шүүгч шүүгдэгчид гэм бурууг нь хүлээлгэхээр дарамталсан тохиолдол Өвөрхангай аймагт нэг удаа гарсан бөгөөд бусад тохиолдолд шүүгдэгчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг гаргуулахаар ямар нэг байдлаар шахалт, дарамт үзүүлсэн тохиолдол гараагүй байна.

Шүүх хуралдааны тасралтгүй байдлыг ажигласан дүнг График 7-д харуулав.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 234 дүгээр зүйлд 234.1, 234.2-т шүүгч шүүх хуралдааныг өдрийн цагаар, амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулах бөгөөд ингэхдээ

хэргийн бүх нотлох баримтыг шинжлэн судлах арга хэмжээ авах үүрэгтэй болохыг заасан. Ийнхүү шүүх хуралдааны тасралтгүй явагдах буюу нотлох баримтыг шинжлэн судлах бүх арга хэмжээ авах нь гэм буруугийд тооцогдох эрхийг хангах, хэрэгжүүлэх чухал хүчин зүйл болно.

4.2. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх

Гэмт хэрэгт холбогдогч нь өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй буюу дуугүй байх эрх нь гэм буруугийд тооцогдох зарчмаас урган гардаг. Тодруулбал, гэмт хэрэгт холбогдогч нь мөрдөгч, прокурор, шүүгчийн тавьсан асуултад хариулах үүрэг хүлээхгүй, ийнхүү дуугүй байсныг нь өөрийнх нь эсрэг баримт болгон ашиглах нь эрс хориотой бөгөөд шүүх хуралдаан

График 7. Шүүгч шүүх хуралдааныг хурдан дуусгахаар хичээж байсан эсэх





График 8. Шүүгч шүүгдэгчид өөрийнхөө болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгсөн эсэх



дээр даргалагч шүүгч энэхүү эрхийг нь шүүгдэгчид тайлбарлаж өгөх үүрэгтэй. График 8-д энэ эрхийн хэрэгжилтийг ажигласан дүнг харуулав.

Ажиглалт явуулсан шүүх хуралдааны 89 хувьд нь шүүгч шүүгдэгчид өөрийнхөө болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгсөн бол 22 шүүх хуралдаан буюу 11 хувьд нь уг эрхийг тайлбарлаж өгөөгүй байна. Энэ нь 2010 онтой харьцуулахад


20 гаруй хувиар, 2015 оныхтой харьцуулахад 2 орчим хувиар өссөн дүн харагдаж байгаа ч үүнийг 100 хувь хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай (Хүснэгт 9).

Шүүгч шүүгдэгчид өөрийнхөө болон гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгснөөр шүүгдэгч энэ эрхээ эдэлж байгаа эсэхийг мөн шүүх хуралдааны үеэр ажиглаж үр дүнг График 9-д харуулав.

Хүснэгт 9. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийн хэрэгжилт (2015, 2017 оны үзүүлэлт)

Үзүүлэлт	2010 он	2015 он	2017 он
Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгсөн	67.9%	87,2%	89%


График 9. Шүүгдэгч өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан эсэх



Ажиглалт явуулсан нийт шүүх хуралдаанаас үзэхэд шүүгдэгч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээ эдэлсэн тохиолдол 22 гарчээ. Түүнчлэн шүүгч шүүгдэгчийг асуултад хариулах үүрэггүй болон

асуултад хариулахаас татгалзах нь өөрийнх нь эсрэг ашиглагдахгүй болохыг тайлбарлаж өгөөгүй тохиолдол 32 гарсан нь нийт шүүх хуралдааны 16 хувийг эзэлж байна (График 10).

График 10. Шүүгч шүүгдэгчийг асуултад хариулах үүрэггүй болон асуултад хариулахаас татгалзах нь өөрийнх нь эсрэг ашиглагдахгүй болохыг шүүгдэгчид тайлбарлаж өгсөн эсэх



Шүүх бүрэлдэхүүн ихэнхдээ шүүгдэгчид “өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй” талаар сануулдаг боловч уг эрхийн агуулгыг задалж сайтар тайлбарладаггүй явдал нийтлэг ажиглагдав. Шүүгдэгч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх нь шүүх хуралдааны бүхий л үе шатанд хэрэгжих бөгөөд

шүүгдэгч асуултад хариулах үүрэггүй. Асуултад хариулахаас татгалзах нь шүүгдэгч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээ эдэлж буй хэлбэр гэдгийг анхаарч энэ тухай шүүгдэгчид тайлбарлаж байхыг хэвшүүлэх шаардлагатай байгаа нь мөн анзаарагдсан юм.

ТАВ.

Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулалгүй шүүлгэх эрхийн хэрэгжилт

Шүүн таслах ажиллагааг огт хойшлуулалгүйгээр явуулахыг хуулиар шууд зохицуулах боломжгүй бөгөөд харин шүүн таслах ажиллагааг үндэслэлгүйгээр, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулахыг хориглодог. Гэмт хэрэгт буруутгагдаж байгаа хүн, ялангуяа цагдан хоригдож байгаа хүн бүр боломжит хугацаанд хэргээ шалгуулах, шүүхээр хэлэлцүүлэх эрхтэй талаар Иргэний болон улсын төрийн эрхийн пактад заасан⁵ бөгөөд энэ нь хүний эрхэм чанар, халдашгүй, чөлөөтэй байх эрх, гэм буруугүйд тооцогдох зарчимтай холбогддог.

Иймд эрх бүхий байгууллага нь шүүн таслах ажиллагааг аль болох боломжит богино хугацаанд явуулах үүрэгтэй.⁶ Нөгөөтэйгүүр гэрчийн ой санамж арилах буюу мэдээллээ алдах, гэрчүүд шүүх хуралдаанд оролцох боломжгүй болох, бусад нотлох баримт үгүй болох буюу арилах зэргээс сэргийлж, хүний өмгөөлөх эрхийг хэрэгжүүлэхийн тулд тодорхой хугацаанд байцаан шийтгэх ажиллагаа явуулахыг зорьдог.⁷ Энэ удаагийн ажиглалтаар шүүх хурлын хойшлолт, шүүх хурал цагтаа эхэлж байгаа эсэхэд мөн ажиглалт хийлээ.

5 Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 9(3) дугаар зүйл. Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй. <http://www.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257>

6 Эмнести Интернэшнл “Шударгаар шүүлгэх эрх” Гарын авлага, Хоёр дахь хэвлэлт, 147 дахь тал

7 Нээлттэй Нийгэм Форум “Шүүх хуралдааны ажиглалт” Судалгааны нэгдсэн тайлан, Н.Туяа нар УБ., 2015, Мөн тэнд.


5.1. Шүүх хуралдааны хойшлолт

Шүүх хуралдааны товыг гурваас доошгүй хоногийн өмнө шүүх талуудад мэдэгдэнэ.⁸ Шүүгчийн захирамжид дурдсан шүүх хуралдааны товыг хуралдаанд оролцогч бүрт мэдэгдэх (утсаар ярих), энэ тухай тэмдэглэл үйлдэж гарын үсэг зуруулах үүргийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээдэг. Гэвч практикт шүүх хуралдаан хойшлох тохиолдол байнга давтагдсаар байна. 2017 оны ажиглалтад сонгосон нийт шүүх хуралдааны 38 хувь нь ямар нэг шалтгаанаар хойшлогджээ (График 11).

2017 онд сонгосон шүүх хуралдаануудын хойшлолт нь 2015 оны үзүүлэлттэй харьцуулахад буураагүй бөгөөд харин ч 1 орчим хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй гарчээ (Хүснэгт 10).

Хүснэгт 10-аас харахад 2015 болон 2017 онд сонгогдсон 3 шүүх хуралдаан тутмын 1 нь хойшилсон дүр зураг харагдаж байна. Чухам ямар шалтгаанаар шүүх хурал хойшилж байгааг тодруулахад 60 гаруй хувь нь шүүгдэгчийн өмгөөлөгчөөс шалтгаалж байгаа нь ажиглагдлаа (Хүснэгт 11).

График 11. Шүүх хуралдаан хойшилсон байдал



Хүснэгт 10. Хойшилсон шүүх хуралдааны харьцуулсан тоон үзүүлэлт

2015 он		2017 он	
Нийт шүүх хуралдаан	Хойшилсон шүүх хуралдаан	Нийт шүүх хуралдаан	Хойшилсон шүүх хуралдаан
159	59	330	125
37.1%		38%	

⁸ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 228 дугаар зүйлийн 228.4-т

Хүснэгт 11. Шүүх хурал хойшилсон шалтгаан (оролцогчдоор)

Ажиглалт	Шүүгч	Улсын яллагч	Өмгөөлөгч	Бусад оролцогч
2010 онд	5,6%	19,4%	44,4%	30,6%
2015 онд	3,3%	22,9%	52,5%	21,3%
2017 онд	3,6%	7,4%	62,5%	26,5%

Яллагч талаас шалтгаалж шүүх хуралдаан хойшилсон тохиолдол 2015 оныхтой харьцуулахад 15.5 хувиар буурсан боловч өмгөөлөгчөөс шалтгаалан шүүх хуралдаан хойшлох явдал 2015 онтой харьцуулахад 10 хувиар өссөн үзүүлэлт гарч байна. Харин өмгөөлөгчөөс болж шүүх хурлыг хойшлуулах болсон шалтгааныг Хүснэгт 12-т дэлгэрүүлэн харуулав.

Ажиглалтын дүнгээс үзэхэд өмгөөлөгч өвчтэй байсан болон өмгөөлөгчийн оролцох бусад шүүх хуралдаантай давхардсан гэсэн үндэслэлээр зонхилж шүүх хуралдаан хойшилсон байна. Хүснэгт 13-т шүүх хурал хойшилсон шалтгааныг аймаг тус бүрээр харуулсан бөгөөд эдгээрээс Дорнод, Хөвсгөл аймгуудад өмгөөлөгчөөс болж тус бүрт 10-13 хурал хойшилж байсан нь ажиглагдав.

Хүснэгт 12. Өмгөөлөгч шүүх хуралдаан хойшлуулсан шалтгаан

Шалтгаан	Давталтын тоо
Шинжээч оролцуулах хүсэлт гаргасан	1
Шүүгдэгчийн өмгөөлөгч гадаад явсан	1
Ар гэрт ажил гарсан	1
Гэрч оролцуулах хүсэлт өмгөөлөгч гаргасан	2
Шүүгдэгчийн өмгөөлөгч хохирогчийг оролцуулах хүсэлт гаргасан	2
Өмгөөлөгч өмгөөлөхөөс татгалзсан	2
Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй	2
Шүүгдэгчийн өмгөөлөгч хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан	3
Хохирогчийн өмгөөлөгч хүсэлт гаргаж хойшлуулсан	6
Сургалтад явсан	9
Өвчтэй	16
Өмгөөлөгч хурал давхардсан	32

Хүснэгт 13. Шүүх хуралдаан хойшилсон шалтгаан (аймаг тус бүрээр)

№	Аймаг	Шүүх хуралдаан хойшилсон шалтгаан
1.	Булган	<ul style="list-style-type: none"> – Өмгөөлөгчийн хурал давхацсан -3 – Шүүгч өвчтэй-1 – Шүүгчид гачигдал гарсан-2 – Гэрч оролцуулах хүсэлт өмгөөлөгч гаргасан -1 – Шинжээч оролцуулах хүсэлт гаргасан – 1 – Хохирогч ирээгүй- 1 – Шүүгч сургалтад явсан-1 – Иргэний нэхэмжлэгчийг шүүх хуралд оролцуулах хүсэлт гаргасан-1 – Шалтгаан бичээгүй -3 тохиолдол
2.	Дархан	<ul style="list-style-type: none"> – Шүүгдэгчийн өмгөөлөгчийн хурал давхацсан - 4 – Шүүгдэгчийн өмгөөлөгч гадаад явсан - 1 – Шүүгдэгчийн өмгөөлөгч хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан- 2 – Шүүгдэгчийн өмгөөлөгч гэрч оролцуулах хүсэлт гаргасан -1 – Шүүгдэгчийн өмгөөлөгч хохирогчийг оролцуулах хүсэлт гаргасан-1 – Хохирогчийн өмгөөлөгчийн хурал давхацсан -2 – Хохирогч ирээгүй -1 – Шүүгдэгч өмгөөлөгч авах хүсэлт гаргасан -1 – Улсын яллагч сургалттай-2
3.	Дорнод	<ul style="list-style-type: none"> – Шүүгдэгчийн өмгөөлөгчөөс шалтгаалж хойшилсон-10 (эрүүл мэндийн шалтгаанаар-5, шүүх хуралдаан давхацсанаас-2, сургалтад хамрагдаж байгаагаас-2, ар гэрт ажил явдал гарснаас-1) – Хохирогч Улаанбаатар хотод эмчилгээ хийлгэж байгаа тухай бичиг өгч, шүүх хуралдаанд өмгөөлөгчтэйгээ өөрийн биеэр оролцох тухай хүсэлт гаргасан-1 – Хохирогч өмгөөлөгч авах хүсэлт гаргасан-1 – Хохирогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хүүхдээ хагалгаанд оруулахаар Улаанбаатар хот руу явсан тул хойшлуулах хүсэлт ирүүлсэн-1 – Хохирогчийн өмгөөлөгч Улаанбаатар хотод нэмэлт нотлох баримт цуглуулах шаардлагатай гэсэн хүсэлт өгсөн-1
4.	Завхан	<ul style="list-style-type: none"> – Шүүгдэгчээс шалтгаалж-4 – Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй-1, эмнэлэгт хэвтсэн-2, үйлчлүүлэгч нь төлбөрийн чадваргүй учраас өмгөөлөхөөс татгалзсан-1 – Улсын яллагч томилолтоор явсан-1 – Хохирогч гэрч оролцуулах хүсэлт гаргасан-1
5.	Орхон	<ul style="list-style-type: none"> – Улсын яллагчаас шалтгаалж -1 – Шүүгдэгч өмгөөлөгч авах хүсэлт гаргасан-3 – Шүүгдэгчийн өмгөөлөгчөөс шалтгаалж-8 – Хохирогч эмчилгээнд явсан өөрийн биеэр шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан -1, хохирогчоос шалтгаалсан-2 – Хохирогчийн өмгөөлөгч хүсэлт гаргаж хойшлуулсан -3 – Иргэдийн төлөөлөгчөөс шалтгаалан-1

№	Аймаг	Шүүх хуралдаан хойшилсон шалтгаан
6.	Өвөрхангай	<ul style="list-style-type: none"> – Улсын яллагчаас-1, – Шүүгдэгчээс шалтгаалж-3, – Шүүгдэгчийн өмгөөлөгчөөс-6 (эрүүл мэндийн, хурал давхацсан шалтгаан) – Хохирогчоос шалтгаалсан -3 (хохилогчид яаралтай ажил гарах, эрүүл мэндийн шалтгаан зэргээс) – Хохирогчийн өмгөөлөгчөөс шалтгаалсан-5 (эрүүл мэндийн болон хохирогчийг заавал шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт)
7.	Өмнөговь	<ul style="list-style-type: none"> – Шүүгчид ар гэрийн гачигдал гарсан-1 – Шүүгдэгчийн өмгөөлөгч ирээгүй, өмгөөлөгч авах эрхээр хангаж хойшлуулсан-1 – Шүүгдэгчийн өмгөөлөгчийн сургалт давхацсан-1
8.	Увс	<ul style="list-style-type: none"> – Шүүгдэгчээс шалтгаалж-1 (шүүх хуралдаанд ирээгүй) – Шүүгдэгчийн өмгөөлөгч-3 (шүүх хуралдаан давхацсан) – Хохирогчоос шалтгаалсан-2
9.	Хөвсгөл	<ul style="list-style-type: none"> – Улсын яллагчаас шалтгаалж-5 (сургалтад явсан-4) – Шүүгдэгчийн өмгөөлөгчөөс шалтгаалж-6 (шүүх хурал давхардсан, сургалтад явсан) – Хохирогчоос шалтгаалж-1 – Хохирогчийн өмгөөлөгчөөс шалтгаалсан-4 – Иргэдийн төлөөлөгч хөдөө явсан-1
10.	Хэнтий	<ul style="list-style-type: none"> – Шүүгдэгчээс шалтгаалж-4 – Шүүгдэгчийн өмгөөлөгч хохирогчийг шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гаргасан-1, Улаанбаатар хот руу томилолтоор явсан-1 – Хохирогчоос шалтгаалж-3 – Хохирогчийн өмгөөлөгчөөс шалтгаалж-1

5.2. Шүүх хуралдаан товлосон цагтаа эхэлж буй байдал

Нийт ажигласан 330 шүүхийн 47 хувьд нь хуралдаан товлосон цагтаа эхэлж, 53 хувь нь товлосон цагаасаа хоцорч эхэлжээ. 2015 онд хийсэн судалгаанд дурдсанаар шүүх хуралдаан товлосон цагтаа эхэлдэг байдал 20 гаруй хувьтай

байсан⁹ бол энэхүү судалгаанаас үзэхэд нийт шүүх хуралдааны 47 хувь нь товлосон цагтаа эхэлсэн байгаа нь энэ чиглэлд ахиц гарч байгааг харуулна. Шүүх хуралдаан цагтаа эхлэхгүй байгаагийн шалтгааныг Хүснэгт 14-т аймаг тус бүрээр дэлгэрүүлэн харуулав.

9 Нээлттэй Нийгэм Форум “Шүүх хуралдааны ажиглалтын тайлан”, Н.Туяа нар, УБ., 2010, 22 дахь тал.

Хүснэгт 14. Шүүх хуралдаан товлосон цагтаа эхлээгүй шалтгаан (аймаг тус бүрээр)

№	Аймаг	Хоцорч эхэлсэн шалтгаан
1.	Булган	– Шүүгч хоцорсон-1 – Шалтгаан тодорхойгүй -14
2.	Дархан	– Өмнөх шүүх хуралдаан оройтож дууссанаас шалтгаалж хоцорч эхэлсэн - 5 – Хэргийн оролцогч нар хоцорсон -12 – Шүүх бүрэлдэхүүн хоцорсон -1 – Бусад 12 шалтгааны улмаас хоцорсон байна.
3.	Дорнод	– Өмнөх шүүх хуралдаан оройтож дууссанаас шалтгаалж хоцорч эхэлсэн - 5 – Хохирогчийн өмгөөлөгч хоцорсноос шалтгаалж хойшилсон-1 – Улсын яллагч хоцорсон-2
4.	Завхан	– Хоцорч эхэлсэн шалтгааныг тэмдэглээгүй-7
5.	Орхон	– Өмнөх шүүх хуралдаан дуусаагүй-1 – Шүүгч хоцорсон-2 – Шүүхийн дотоод ажил гарсан шалтгаанаар -1 – Өмгөөлөгч хоцорсон-1 – Цахилгааны саатал гарснаар-1 – Прокурор хоцорсон-1 – Шүүгдэгч хоцорсон-2
6.	Өвөрхангай	– Хохирогч хоцорсон-1 – Шүүгч хоцорсон-2 – Шүүгдэгч хоцорсон-2 – Өмнөх шүүх хуралдаан дуусаагүй -4 – Иргэдийн төлөөлөгч ирснийг мэдээгүй шалтгаанаар-1 – Прокурор хоцорсон-1
7.	Өмнөговь	– Шүүгч нар сургалттай байсан -1 – Өмнөх шүүх хуралдаан дуусаагүй -6 – Шүүгч хоцорсон-1 – Шалтгаан тодорхойгүй -2
8.	Увс	– Шүүгдэгчийн өмгөөлөгч хоцорсон-1 – Хохирогч хоцорсон-2 – Өмнөх шүүх хуралдаан дуусаагүй -3
9.	Хөвсгөл	– Нарийн бичгийн дарга зар өөрчлөгдсөнийг мэдэгдээгүй-1 – Шүүгч хоцорсон-10 – Прокурор хоцорсон-3 – Өмнөх шүүх хуралдаан дуусаагүй -1 – Шүүгдэгчийн өмгөөлөгч хоцорсон-2 – Шалтгаан тодорхойгүй -7
10.	Хэнтий	– Өмнөх шүүх хуралдаан дуусаагүй -1 – Шүүгч тодруулга хийх шаардлагатай байсан-1 – Шүүгдэгч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн-1 – Шалтгаан тодорхойгүй -3

Хүснэгт 15. Шүүх хуралдаан товлосон цагаасаа хоцорч эхэлсэн шалтгаан

Шалтгаан	Давталтын тоо
Шүүгч хоцорсон	25
Өмнөх шүүх хуралдаан дуусаагүй	26
Улсын яллагч хоцорсон	7
Шүүгдэгч болон хохирогчийн өмгөөлөгчөөс шалтгаалсан	5
Шүүхийн дотоод ажил гарсан	1
Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны зар өөрчлөгдсөнийг мэдэгдээгүй	1
Цахилгааны саатал гарсан	1
Шүүгдэгч хоцорсон	4
Шүүгдэгч согтууруулах ундаа хэрэглэсэн байснаас болсон	1
Хохирогч хоцорсон	3
Шүүгч тодруулга хийх шаардлагатай гэж үзсэн	1
Ажиглагчид шүүх хуралдаан товлосон цагаасаа хоцорч эхэлсэн шалтгааныг мэдэж чадаагүй	50

Ажиглалтын дүнгээс үзэхэд шүүгчээс шалтгаалж шүүх хуралдаан товлосон цагтаа эхлээгүй тохиолдол бусад шалтгаантай харьцуулахад харьцангуй өндөр байгааг анхаарах шаардлагатай байна. Гэхдээ зарим тохиолдолд шүүгчээс өөрөөс нь шалтгаалахгүйгээр /бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд оролцох г.м/ шүүгч товлосон цагтаа шүүх хуралдааныг

эхлүүлж чадахгүй байх тохиолдол гарч байхыг үгүйсгэхгүй юм.

Аймаг тус бүрээр гаргасан дээрх шалтгааныг бүлэглэн Хүснэгт 15-д үзүүлэв. Эндээс харахад ажиглагчид 50 хуралдааны хойшилсон шалтгааныг мэдэж чадаагүй буюу хойшилсон шалтгаан тодорхойгүй байгаа нь мөн анхаарал татаж байна.

ЗУРГАА.

Өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт

Хүн бүр өөрийгөө өмгөөлөх эсхүл өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй бөгөөд өөрөө өмгөөлөгчөө чөлөөтэй сонгож, төлбөр төлж хууль зүйн туслалцаа авч чадахгүй бол талуудын тэгш байдлыг хангах үүднээс төрөөс томилсон мэргэжлийн өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй.¹⁰

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т “Монгол Улсын иргэн: “..., өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, ... эрхтэй...” хэмээн зааж өмгөөлүүлэх эрхийг хангах эрх зүйн үндсийг тогтоосон. Улмаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана”, 17.3-т “өмгөөлөгч нь шүүгдэгчийг өмгөөлөхийн тулд хуульд заасан бүхий л арга хэрэгслээр хууль зүйн туслалцаа үзүүлнэ”, 17.4-т “талууд

шүүх хуралдааны үед нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, хэрэгт ач холбогдол бүхий ямар ч асуудлаар саналаа илэрхийлэх талаар эрх тэгш байна”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй” хэмээн заасан.

Өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцоходоо Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 241 дүгээр зүйлийн 241.1-д зааснаар нотлох баримт шинжлэхэд оролцох, шүүх хуралдааны явцад гарсан асуудлаар санал гаргах, шүүгдэгчийг цагаатгах, түүний хариуцлагыг хөнгөрүүлэх байдлын тухай болон шүүгдэгчид оногдуулах ялын талаар саналаа хэлэх эрхтэй.

Ажиглалт хийсэн нийт шүүх хуралдааны 76 хувьд нь шүүгдэгч өмгөөлөгч авсан байгаа нь 2015 оны судалгааны дүнтэй харьцуулахад бага

Хүснэгт 16. Өмгөөлөгчийн оролцоо

Үзүүлэлт	2015 он	2017 он
Шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгч оролцсон байдал	83.1%	76%
Шүүгдэгч төрөөс томилогдсон өмгөөлөгч авсан байдал	23.5%	25%
Шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байдал	19.5%	34.17%

10 Нээлттэй Нийгэм Форум “Шүүх хуралдааны ажиглалт” Судалгааны нэгдсэн тайлан, Н.Туяа нар УБ., 2015, 23 дахь тал.

зэрэг буурсан байгаа ч шүүгдэгч улсын өмгөөлөгч авсан байдал 2015 онтой харьцуулахад бага зэрэг өссөн байна. Мөн хохирогчийн өмгөөлөгчийн оролцоо 2015 онтой харьцуулахад нэлээд өссөн үзүүлэлттэй гарчээ. Мөн 8 тохиолдолд шүүгдэгч өмгөөлөгч авах хүсэлт гаргасан байна. Шүүх хуралдаан дахь өмгөөлөгчдийн оролцооны байдлыг Хүснэгт 16-д бүлэглэн 2015 оны судалгааны дүнтэй харьцуулан харуулав.

Шүүх хуралдааны үед шүүгдэгчийн өмгөөлөгч өөрийн үйлчлүүлэгчтэйгээ хэрхэн харьцаж байгаа талаар судлахад 98.1 хувь нь хэвийн, 0.6 хувь нь дээрэнгүй, 1.8 хувь нь үл тоомсорлосон байдалтай харьцаж байсан гэсэн үзүүлэлт гарчээ. Гэхдээ 2015 оны судалгааны

дүнтэй харьцуулахад дээрэнгүй, үл тоомсорлосон байдал нэлээд буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа юм (Хүснэгт 17).

Ажиглалтын дүнгээс харахад нийт хэргийн 1.8 хувьд нь шүүгдэгч өмгөөлөгчөөсөө татгалзах хүсэлт гаргасан байна. Хоёр тал төлбөрийн талаар санал зөрөлдсөн, өөрийг нь өмгөөлөх шаардлага хангаагүй, төрөөс томилогдсон өмгөөлөгч мэргэжлийн ур чадваргүй гэсэн үндэслэлээр 3 тохиолдолд шүүгдэгч өмгөөлөгчөөсөө татгалзжээ.

Өмгөөлөгч нь шүүхэд төлөөлөх, шүүн таслах ажиллагаанд оролцох эрхтэй, чөлөөт, бие даасан мэргэжилтэн¹¹, мөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан хохирогч,

Хүснэгт 17. Шүүх хуралдаан дахь өмгөөлөгчийн оролцооны талаарх ажиглалтын дүн

Үзүүлэлт	2015 он	2017 он
<i>Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхээ эдлэх хүсэлтэй байхад шүүгч уг эрхийг нь эдлүүлээгүй хязгаарласан уу?</i>	Тийм (2%)	Үгүй
<i>Шүүх хуралдааны үеэр шүүгдэгчийн өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчтэй харилцаж байсан харилцааны хэв маягийг тодорхойлно уу?</i>	Хэвийн (94.5%) Дээрэнгүй (3.3%) Үл тоомсорлосон (2.2%)	Хэвийн (98.1%) Дээрэнгүй (0.6%) Үл тоомсорлосон (1.8%)
<i>Шүүх хуралдааны үеэр өмгөөлөгч шүүгдэгчтэй харилцах боломжийг тодорхойлно уу?</i>	Харилцан ярилцах боломжгүй байсан (14.3%)	Харилцах боломжтой (83.3%) Харилцах боломжгүй (9.9%) Харилцах боломж хязгаарлагдмал (6.8%)
<i>Шүүгдэгч өмгөөлөгчөөсөө татгалзах хүсэлт гаргасан уу?</i>	-	Үгүй (98.2%) Тийм (1.8%)


11 Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийг 30.6 дахь хэсэг

иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль туслалцаа авах эрхээр хангах зорилгоор¹² эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий субъект болохын хувьд тэдэнд мэргэжил, ур чадварын хувьд өндөр шаардлага тавигддаг. Ажиглалтын дүнгээс үзэхэд шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо хэргийн материалтай танилцсан байдал нь 95.7 хувьтай гарчээ.

Өмгөөлөгч хэргийн материалыг хуулбарлан авах нь үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн дүүрэн хамгаалах, хэрэг, маргаанд дүн шинжилгээ хийхэд ач холбогдолтой байдаг. Гэтэл шүүгдэгчийн өмгөөлөгчдийн 48.4 хувь нь л шүүх хуралдаанд оролцохдоо хэргийн материалыг хуулбарлаж авсан байгаа нь хангалтгүй үзүүлэлт гэж үзэж болохоор байна.

Орон нутагт хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрх хэр хэмжээнд хэрэгжиж байгаа, тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон өмгөөлөгч мэргэжил, ур чадварын хувьд хангалттай байгаа эсэхийг тодруулах зорилгоор шүүх хуралдааны ажиглалтын хуудаст “улсын яллагчтай харьцуулахад өмгөөлөх тал хүчин чадал сул байсан уу?” гэх асуулт өгөгдсөн бөгөөд дүнг График 12-т харуулав.

График 12. Улсын яллагчтай харьцуулахад өмгөөлөх тал хүч сул байсан эсэх



Хүснэгт 18. Өмгөөллийн үйл ажиллагааны чанарыг үнэлсэн байдал

Үзүүлэлт	2017 он
Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо хэргийн материалыг хангалттай сайн судалж, танилцсан байсан уу?	Тийм (95.7%) Үгүй (4.3%)
Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо хэргийн материалыг хуулбарлаж авсан байсан уу?	Тийм (48.4%) Үгүй (51.6%)
Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд идэвхтэй мэтгэлцэж оролцсон уу?	Тийм (94.9%) Үгүй (5.1%)

12 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

Ажиглалтын дүнгээс үзэхэд шүүх хуралдааны ажиглалтын тайланд хамрагдсан өмгөөлөгч нар мөн судалгаанд хамрагдсан улсын яллагч нартай мэргэжил, ур чадварын хувьд ижил хэмжээнд байж, шүүх хуралдаан өмгөөлөх болон яллах тал эрх тэгш,

мэтгэлцээний үндсэн дээр явагдсан гэж үзэж болохоор байна. Харин нийт шүүх хуралдааны 6 хувьд буюу 11-д нь өмгөөлөх тал яллах талтай харьцуулахад хүчин чадал сул байсан гэж ажиглагч нар үзжээ.

ДОЛОО.

Орчуулагч, хэлмэрч авах эрхийн хэрэгжилт

Гэмт хэрэгт холбогдсон хүн шүүн таслах ажиллагаа явуулж буй хэлийг мэдэхгүй, эсхүл хэл ярианы бэрхшээлтэй бол мэргэшсэн орчуулагч, хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй байдаг. Өөрөөр хэлбэл, шүүн таслах ажиллагаа явуулж буй хэлийг мэдэхгүй, ойлгохгүй бол түүнд ойлгомжтой, зөв аман болон бичгийн орчуулга хийж өгөх, хэл ярианы бэрхшээлтэй бол хэлмэрч авах нь хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг хэрэгжүүлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад чухал.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 256 дугаар зүйлийн 256.1 дэх хэсэгт орчуулагч, хэлмэрч нь хуралдаанд оролцож байгаа монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий хүний мэдүүлэг, хүсэлтийг шүүхэд; шүүх

хуралдаан дээр гаргасан мэдүүлэг, хүсэлт, уншсан баримт бичиг, түүнчлэн шүүх хуралдаан даргалагчийн болон шүүхийн шийдвэрийг орчуулуулж, хэлмэрчлүүлж байгаа хүнд орчуулж, хэлмэрчилж өгөх үүрэгтэй болохыг шүүх хуралдаан даргалагч тайлбарлаж өгөх бөгөөд мөн хуулийн 256 дугаар зүйлийн 256.2 дахь хэсэгт хэрэв санаатайгаар худал орчуулах, хэлмэрчлэх тохиолдолд хариуцлага хүлээлгэхийг сануулж гарын үсэг зуруулахаар заасан байдаг.

Ажиглалт хийсэн нийт эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд орчуулагч, хэлмэрч оролцсон тохиолдол гараагүй, мөн шүүгдэгчийн зүгээс орчуулагч, хэлмэрч авахаар хүсэлт гаргасан тохиолдол гараагүй байна.

НАЙМ.

Нотлох баримт гаргах, үнэлүүлэх эрхийн хэрэгжилт

Нотлох ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналтын шатанд төдийгүй шүүхийн ажиллагааны явцад буюу шүүх хуралдаан дээр хийгддэг учраас хэргийн оролцогчийн зүгээс нотлох баримт гаргах, үнэлүүлэх эрхээ хуульд заасны дагуу эдлэх эрхтэй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 92 дугаар зүйлийн 92.3 дахь хэсэгт заасны дагуу шүүгдэгч, өмгөөлөгч, улсын яллагч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч нь баримт сэлт гарган өгч болно. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 95 дугаар зүйлийн 95.1 дэх хэсэгт зааснаар шүүх тухайн хэрэгт хамааралтай, хуулийн дагуу цуглуулж, баталгаажуулж авсан бүх нотлох баримтыг хэрэг хянан

шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ.

Шүүгдэгчийг мэдүүлэг өгч байхад нь ямар нэг байдлаар тасалдуулсан тохиолдол гараагүй байна. Шүүх хуралдаанд шүүгдэгчийн мэдүүлгийг таслалгүй сонсож байгаа нь шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 263 дугаар зүйлийн 263.1 дэх заалтыг хэрэгжүүлж байна гэж дүгнэхээр байна. Ажигласан шүүх хуралдааны нотлох баримтуудын танилцуулсан хэлбэрийг Хүснэгт 19-д нэгтгэж харуулав.

Шүүх хуралдаан дээр нотлох баримтыг танилцуулсан хэлбэрүүдээс нийт 161 удаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсгосон нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Эндээс харахад гэрчийн мэдүүлэг нь эрүүгийн хэрэг

Хүснэгт 19. Нотлох баримтын хэлбэрүүд

Үзүүлэлт	2017 он	Тоо
Шүүх хуралдаан дээр нотлох баримтыг танилцуулсан хэлбэрүүд	Бичгийн хэлбэрээр	113
	Гэрчийн мэдүүлгийг уншиж	161
	Шинжээчийн дүгнэлтийг уншиж	85
	Гэрч, шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулж	7
	Дуу, дүрс бичлэг үзүүлэх	3
	Бусад хэлбэрээр: Фото зураг харуулсан	1
	Эд мөрийн баримт үзүүлсэн	3
Шүүгдэгч нотлох баримт мэдүүлэг өгөхөөс татгалзсан	1	

маргаан шийдвэрлэх үндсэн нотлох баримт болдог хэдий ч тэдний шүүх хуралдаанд оролцож өөрсдийн өгсөн мэдүүлгийг баталгаажуулах байдал маш хангалтгүй буюу шүүх хуралд биечлэн оролцох тохиолдол ховор байгаа нь цаашид судлах асуудлын нэг гэж үзлээ. Мөн 7 удаа гэрч, шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулсан боловч яллах, эсхүл өмгөөлөх талын алиных нь хүсэлтээр хэдэн удаа гэрч, шинжээч

шүүх хуралдаанд оролцсон эсэх нь тодорхойгүй байна (Хүснэгт 20).

Нийт шүүх хуралдааны 10 хувьд нь дуу, дүрс бичлэгээр үзүүлэх нотлох баримтыг бүрэн, тодорхой үзүүлэх боломж, нөхцөл хангагдаагүй гэж дүгнэсэн байгаа ба үүний 53 хувийг Булган аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, 26 хувийг Өмнөговь аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх эзэлж байв.

Хүснэгт 20. Нотлох баримт гаргах, үнэлүүлэх эрхийн хэрэгжилтийг дүгнэсэн байдал

Үзүүлэлт	Тийм
<i>Дуу, дүрс бичлэгээр үзүүлэх нотлох баримтыг бүрэн, тодорхой үзүүлэх боломж, нөхцөл хангагдсан байсан уу?</i>	89.8%
<i>Шүүх хуралдаанд яллах талын гэрч оролцсон уу?</i>	0.5%
<i>Шүүх хуралдаанд цагаатгах талын гэрч оролцсон уу?</i>	1%
<i>Гэрчээс мэдүүлэг авах хүртэл түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргасан уу?</i>	25%
<i>Шүүгч гэрчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн үү?</i>	75%
<i>Шүүгч гэрчид худал мэдүүлэг өгвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг сануулсан уу?</i>	50%
<i>Шүүх хуралдаанд шинжээч оролцсон уу?</i>	2%
<i>Шүүгч шинжээчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн үү?</i>	66.6%
<i>Шүүх хуралдааны үеэр шинжээчээс мэдүүлэг авсан уу?</i>	75%
<i>Шүүгч шүүгдэгчид шинжээчийг татгалзах эрхийг нь тайлбарлаж өгсөн үү?</i>	0
<i>Шинжээчийн дүгнэлтийг хэлэлцэсний дараа нэмэлт болон дахин шинжилгээ хийлгэх асуудлаар хэргийн оролцогчид хүсэлт гаргасан уу?</i>	3.6%
<i>Нотлох баримтаа дэмжих ямар нэгэн нэмэлт санал байгаа эсэх талаар шүүгч талуудаас асуусан уу?</i>	81.1%
<i>Мөрдөн байцаалтын үеэр шүүгдэгчид сэтгэл зүйн болон бие махбодын дарамт учруулсан (албадлага), эрүү шүүлт хэрэглэсэн, хэрцгий харьцсан, заналхийлсэн, хууран мэхлэх болон бусад хууль бус арга хэрэгслийг ашигласан хэмээн шүүгдэгч өмнө өгсөн мэдүүлгээ буцаасан уу?</i>	1.8%

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 257 дугаар зүйлийн 257.1-д “Гэрчийн мэдүүлгийг сонсох хүртэл түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргана” гэж заасан байдаг хэдий ч Завхан, Орхон, Хөвсгөл аймгуудын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээр ажигласан тус бүр 1, нийт 3 шүүх хуралдаанд гэрчээс мэдүүлэг авах хүртэл түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргаагүй зөрчил гарчээ.

Мөн Орхон аймагт болсон 1 шүүх хуралдаанд шүүгч гэрчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгөөгүй, Орхон болон Хөвсгөл аймагт болсон тус бүр 1 шүүх хуралдаанд шүүгч гэрчид худал мэдүүлэг өгвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг сануулаагүй байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх

тухай хуулийн 266 дугаар зүйлийн 266.2 дахь хэсэг заасан журам зөрчигдсөн байгааг харуулж байна. Мөн шинжээч оролцсон 4 шүүх хуралдаанаас Өвөрхангай аймгийн 1 шүүх хуралдаанд шүүгч нь шинжээчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгөөгүй тохиолдол гарчээ.

Мөрдөн байцаалтын үеэр шүүгдэгчид сэтгэл зүйн болон бие махбодын дарамт учруулсан (албадлага), эрүү шүүлт хэрэглэсэн, хэрцгий харьцсан, заналхийлсэн, хууран мэхлэх болон бусад хууль бус арга хэрэгслийг ашигласан хэмээн шүүгдэгч өмнө өгсөн мэдүүлгээ буцаасан тохиолдол Булган, Завхан, Хөвсгөл аймагт тус бүр 1, нийт 3 удаа гарчээ.

ЕС.

Шүүхийн шийдвэр

Шүүхийн шийдвэрийн үндэслэл нь шүүгдэгчийн давж заалдах эрхийн гол үндэс болдог. Тиймээс шүүхийн шийдвэр нь хэргийн бодит байдал хийгээд түүнийг нотлох хуульд заасан арга хэрэгслээр цуглуулсан, хавтаст хэрэгт авагдсан, шүүх хуралдааны үеэр хэлэлцэгдэж, шинжлэн судлагдсан нотлох баримтад үндэслэн гарах бөгөөд үүнийг шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал гэж ойлгоно.

Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах эрхтэй талаар шүүх хуралдаан даргалагч оролцогч нарт тайлбарлаж өгөх үүрэгтэй боловч нийт хэргийн 3 хувь буюу 6 тохиолдолд уг эрхийг сануулж тайлбарлаагүй байна.

Шударгаар шүүлгэх эрхийн хүрээнд шүүх нь шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлаж өгөх үүрэгтэй. Ажиглалт хийсэн шүүх хуралдаануудад шүүх хуралдаан даргалагч шүүхийн

тогтоолыг шүүгдэгчид тайлбарлан ойлгуулсан байдал хангалттай хэмжээнд хэрэгжжээ.

Түүнчлэн ажиглагч нарын дүгнэж байгаагаар нийт хэргийн 99 хувьд нь шүүхийн тогтоол хангалттай, бүрэн дүүрэн нотлох баримтад тулгуурлаж гарсан байна. Ажигласан шүүхийн тогтоолын агуулгыг Хүснэгт 21-д нэгтгэж харуулав.

2017 оны ажиглалтын үр дүнг 2015 оныхтой харьцуулахад шүүхээс шүүгдэгчийг цагаатгасан тохиолдол харьцангуй өндөр үзүүлэлттэй гарсан бол хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах тохиолдол харьцангуй буурсан байна. Мөн хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдол 2015 оныхтой харьцуулахад эрс өссөн дүн гарчээ.

Хүснэгт 21. Шүүхийн тогтоолын агуулга

Үзүүлэлт	2015 он	2017 он
<i>Шүүгдэгчийг цагаатгасан</i>	1%	21(12%)
<i>Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон</i>	41,2%	70(39%)
<i>Шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон боловч Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу ялыг өршөөн хэлтрүүлсэн</i>	1%	7(4%)
<i>Хавтаст хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан</i>	9,3%	5(4%)
<i>Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч тэнссэн</i>	37,1%	51(28%)
<i>Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч ял эдлүүлэхийг хойшлуулсан</i>	4,1%	3(2%)
<i>Хэргийг хэрэгсэхгүй болгосон</i>	4,1%	20(11%)
<i>Шүүгдэгчид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн</i>	1%	1(0%)

Б

ШҮҮХ ХУРАЛДААНЫ ЗАРИМ СУБЪЕКТҮҮДИЙН ОРОЛЦОО

Шүүх хуралдааны энэхүү ажиглалтаар хуралдаанд оролцогч зарим онцгой субъект болох хохирогч, шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны

хэвийн ажиллагааг хангах үүрэг бүхий шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн хуяг нарын оролцоо, биеэ авч яваа байдал зэргийг авч үзлээ.

НЭГ.

Хохирогч

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д тодорхойлсноор гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ. Хохирогч, түүний төлөөлөгч нь өмгөөлөгч авах, баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах, шүүх хуралдаанд оролцох, шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах, хэрэг бүртгэл, мөрдөн

байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах, гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй болохыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт заажээ. Энэхүү үзүүлэлтийг үндэслэн хохирогч болон түүний өмгөөлөгчийн шүүх хуралдааны оролцоог ажигласан дүнг Хүснэгт 22-г харууллаа.

Үзүүлэлт	2015 он	2017 он
Шүүх хуралдаанд хохирогч оролцсон байдал	37%	37.7%
Шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон байдал	19.5%	34.17%

Ажиглалтын дүнгээс үзэхэд шүүх хуралдаанд хохирогчийн оролцооны байдал 2015 онтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Харин шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгчийн оролцооны байдал 2015 онтой харьцуулахад нэлээд өссөн үзүүлэлттэй гарчээ.

ХОЁР.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч

Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нь түүгээр дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгийн буюу олон нийтийн хяналтыг бий болгох зорилготой. Нөгөөтэйгүүр шүүхийн нээлттэй, илт тод байдлыг хангахад иргэдийн төлөөлөгчийн ач холбогдол их байдаг.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д “иргэдийн төлөөлөгч нь шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогчид асуулт тавих эрхтэй бөгөөд нотлох баримтыг судалж үнэлсний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргах эрхтэй. Иргэдийн төлөөлөгч саналаа шүүх хуралдаанд уншиж сонгож болно”, 34.2-т “шүүх анхан шатны журмаар

хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэхэд 3 иргэдийн төлөөлөгчийг оролцуулна”, мөн хуулийн 261 дүгээр зүйлийн 261.3-т “шүүгч, иргэдийн төлөөлөгч нотлох баримтыг шинжлэхэд оролцож, аль ч үед тодруулах асуулт тавих эрхтэй” гэж тус тус заасан.

2015 онд хийсэн судалгаагаар ажиглалт хийсэн шүүх хуралдааны 20.6 хувьд иргэдийн төлөөлөгч оролцсон бол энэ удаагийн ажиглалтаар нийт шүүх хуралдааны 20 хувьд нь иргэдийн төлөөлөгч оролцжээ. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч шүүгдэгчийн гэм буруугийн талаарх дүгнэлтээ уншиж сонсгодоггүй байдал нийтлэг байгаа нь ажиглалтын дүнгээс харагдаж байна (График 13).

График 13. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо



ГУРАВ.

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

Шүүхийн захиргааны тухай хуулийн 27 дугаар зүйлд бүх шатны шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ажиллана. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь хуралдаан даргалагчийн удирдлага дор дараах чиг үүргийг хэрэгжүүлэхийг тусгажээ. Үүнд шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэл хангах, шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх, шүүх хуралдааныг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулах, шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчид хуульд заасан хугацаанд танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэргийн материалд хавсаргах чиг үүргийг

хэрэгжүүлнэ. Шүүх хуралдааны явц дахь нарийн бичгийн даргын оролцоог Хүснэгт 23-т нэгтгэн харуулав.

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны бэлтгэлийг бүрэн хангах, шаардлагатай техник хэрэгслийг шүүх хуралдаан эхлэхээс өмнө бэлэн болгох, албаны байдлаар хувцаслах, оролцогчдыг шүүх хуралдааны танхимд зохих байрыг эзлүүлэн суулгасан байх зэрэг нь 2015 онд хийсэн судалгаатай харьцуулахад өссөн үзүүлэлттэй, ахиц гарсан байгаа нь ажиглалтын дүнгээс харагдаж байна.

Хүснэгт 23. Шүүхийн нарийн бичгийн даргын оролцоо

Үзүүлэлт	2015 он	2017 он
Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны бэлтгэлийг бүрэн хангасан байсан		100%
Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шаардлагатай техник хэрэгслийг шүүх хуралдаан эхлэхээс өмнө бэлэн болгосон байсан	94,9%	98,8%
Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга албаны байдлаар хувцасласан байсан	95,9%	98,8%
Шүүх хуралдаан эхлэхэд бүх оролцогчид зохих байраа эзэлсэн байсан	92,8%	100%

ДӨРӨВ. Шүүхийн хуяг

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т “Шүүх хуралдааны журам сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үүргийг цагдаагийн алба гүйцэтгэнэ” гэж заасан.

Тахарын албаны тухай хуульд заасны дагуу шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Тахарын байгууллага хариуцан хэрэгжүүлж байсан боловч Улсын Их Хурлаас баталсан 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар Тахарын албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсоноор шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг буцаад цагдаагийн байгууллага хэрэгжүүлж байна. Улмаар 2016 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан


А/40, 113 дугаар тушаалаар “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг батлан мөрдөж байна.¹³

Шүүхийн хуягийн нэг гол үүрэг нь шүүх хуралдааны дэг журам сахиулах үүрэг ба хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны үед шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдааны танхимд орж ирэх үеэс эхлэн хуралдаан хаах хүртэлх хугацаанд хуралдааны танхимын аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэгтэй. Сонгож ажигласан 330 шүүх хуралдааны танхимын 96.6 хувьд нь хуяг ажиллаж байсан ажээ (График 14).

Мөн 97.6 хувьд нь шүүхийн журам сахиулах хуяг хуралдааныг дуустал танхимд байсан байна. Харин Орхон аймгийн хувьд 36 шүүх хуралдааны 6-д, Өмнөговь аймагт 29 шүүх хуралдааны 1-д, Увс аймагт 19 шүүх хуралдааны 2-т нь журам сахиулах хуяг байхгүй гэсэн сөрөг үр дүн гарсан байна.

¹³ <http://www.legalinfo.mn/annex/details/7418?lawid=12157>

График 14. Шүүх хуралдааны танхимд журам сахиулах хуяг байсан эсэх



В

ШҮҮГЧ, ШҮҮХИЙН АЖИЛТНУУДЫН ХАРИЛЦААНЫ БАЙДАЛ

Ажиглалтын дүнгээс харахад шүүгч, шүүхийн ажилтнуудын харилцаа ихэнх тохиолдолд энгийн бөгөөд шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдийн хувьд тэдэнтэй харилцахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгарахгүй байгаа нь харагджээ (Хүснэгт 24). Харин шүүгч

шүүх хуралдааны оролцогч нартай харилцахдаа цөөн тохиолдолд буюу 1.2 хувьд нь хүйтэн, хөндий харилцаатай байсан гэж дүгнэжээ. Илэрхий бүдүүлэг дээрэнгүй, ялгамжтай харилцаа аль ч ажилтны хувьд ажиглагдаагүй байна.

Хүснэгт 24. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны харилцаа

Үзүүлэлт	Эелдэг, уриалгахан	Энгийн	Хөндий, хүйтэн	Бүдүүлэг, дээрэнгүй	Ялгамж-тай	Мэдэх-гүй
<i>Шүүхийн харуул хуягийн иргэдтэй харилцах байдал</i>	6.8%	93.2%	-	-	-	-
<i>Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын харилцаа</i>	6.1%	93.9%	-	-	-	-
<i>Шүүхийн дэг сахиулах хуягийн харилцаа</i>	0.8%	99.2%	-	-	-	-
<i>Шүүгч шүүх хуралдааны оролцогч нартай харилцах байдал</i>	2.3%	96.5%	1.2%	-	-	-

Г

ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДЭГ ХАНГАГДАЖ БҮЙ БАЙДАЛ

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 237 дугаар зүйлийн 237.3-т “Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авч оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлан өгнө”, мөн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.1-д “Шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг танхимд орж ирэхэд шүүх хуралдааны танхимд байгаа хүмүүс бүгд босож, шүүхэд хүндэтгэл үзүүлнэ” гэсэн заалтууд хуулийн дагуу хэрэгжиж байгаа нь ажиглагдлаа (Хүснэгт 25).

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 237 дугаар зүйлийн 237.3-т зааснаар шүүх хуралдааны даргалагч нь шүүх хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд шүүгдэгч шүүх хуралдааны дэгийг зөрчвөл хуралдааны танхимаас гаргах


тухай урьдчилан сануулах ба дахин ийм зөрчил гаргавал шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хуралдааны танхимаас гарган торгууль ногдуулах эрхтэй. Ажигласан шүүх хуралдааны 98.5 хувьд дээрх заалт хуулийн дагуу хэрэгжиж байгаа ч нэг тохиолдолд дэг зөрчигдсөнөөс шүүх хуралдаан хойшилжээ (График 15).

Шүүх хуралдааны дэгийг байнга биш хэдий ч утсаар ярих, хоорондоо ярих гэх мэт жижиг зөрчлүүд ажиглагдсан болно. Нэг тохиолдолд шүүгдэгч согтуугаар шүүх хуралдаанд оролцох үйлдэл гаргаж шүүх хуралдааны дэг зөрчигдөж улмаар уг хуралдааныг шүүгч хойшлуулсан байна.

Хүснэгт 25. Шүүх хуралдааны дэг

Үзүүлэлт	2017 он
Шүүх бүрэлдэхүүн орж ирэхэд шүүхийн танхимд байсан хүмүүс босож хүндэтгэл үзүүлсэн	100%
Шүүх хуралдааны дэгийг оролцогчдод тайлбарлаж таниулсан	100%

График 15. Шүүх хуралдааны дэг зөрчигдсөн эсэх



Д

ШҮҮХИЙН БАЙРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

НЭГ.

Шүүхийн байрны тохижилт болон хүндэтгэл төрүүлэхүйц байдал

Шүүхийн захиргааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-т “шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй байлгах, аюулгүй байдлыг хангах стандартад нийцсэн шүүхийн байр, хуралдааны танхим болон бусад барилга байгууламж барих, засвар хийх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төлөвлөх, зураг төсвийг захиалан боловсруулж, гүйцэтгэлийг хангах” чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлэхээр заасан байна.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын Шүүхийн байрны нийтлэг шаардлагын 3 дугаар зүйлийн 3.1-т “Шүүх хуралдааны танхимд шүүн таслах ажлыг олон нийтэд нээлттэй, ил тод явуулах, эрүүл, аюулгүй байх, хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэж баталсан байна. Хуулийн дээрх заалт болон тогтоолын хэрэгжилттэй холбогдох асуудлыг тусган мөн ажиглалт хийхэд шүүхийн байрны нөхцөл байдал 2010, 2015 оны байдалтай харьцуулахад сайжирсан байгаа нь харагдлаа (Хүснэгт 26).

Хүснэгт 26. Шүүхийн байрны нөхцөл байдал

Үзүүлэлт	2010 он	2015 он	2017 он
Шүүхийн байр нь цэвэр цэмцгэр, хүндэтгэл төрүүлэхүйц байсан	85.3%	95.8%	100%
Шүүх хуралдааны танхим цэвэр, тохилог, хүндэтгэл төрүүлэхүйц байсан	78.6%	96.4%	100%

Иргэдэд үйлчлэх, тэр дундаа шүүн таслах онцгой эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага болохын хувьд шүүхийн байр нь хүндэтгэл төрүүлэхүйц, цэвэр тохилог, зай талбайн хувьд хүртээмжтэй, иргэдэд шаардлагатай мэдээллийг зохих хэлбэрээр хүргэдэг, шүүн таслах

ажиллагаа иргэдэд хүртээмжтэй, хуульд заасан журмын дагуу явагддаг байх зэрэг шаардлагыг хангаж ажиллах учиртай. Энэ удаагийн ажиглалтын үр дүнгээс харахад шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын цэвэр цэмцгэр, хүндэтгэл төрүүлэхүйц байжээ.

ХОЁР.

Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулж архивт хадгална” гэж заасны дагуу шүүх хуралдаанд оролцогчдын яриа тод сонсогдож, хуралдааны чанга яригч хэвийн ажиллаж байх шаардлагыг тавьжээ. Хуулийн энэ заалтын хэрэгжилтийг ажиглаж үр дүнг Хүснэгт 27-д нэгтгэн харуулав.

2015 оны ажиглалтын судалгаатай харьцуулахад шүүхийн тоног төхөөрөмжийн байдалд ахиц гарсан нь судалгаанаас харагдаж байна. 2015 онд шүүх хуралдаанд оролцогчдын яриа харилцан сонсогдохгүй, техник хэрэгсэл нь хэвийн бус байх тохиолдол гарч байсан¹⁴ боловч энэхүү ажиглалтаар ийм тохиолдол гараагүй байна. Мөн шүүх хуралдааны микрофон, чанга яригч хэвийн ажиллагаатай байх явдалд ахиц гарчээ.

Хүснэгт 27. Шүүх хуралдааны танхимын техник, тоног төхөөрөмжийн ажиллагаа

Үзүүлэлт	2015 он	2017 он
Шүүх хуралдаанд оролцогчдын яриа тод сонсогдож байсан уу?	-	100%
Шүүх хуралдааны микрофон, чанга яригч хэвийн ажиллагаатай байсан уу?	95.5%	98.8%
Шүүх хуралдааны үеэр аудио бичлэг хийгдэж байсан уу?		98.8%

14 Нээлттэй Нийгэм Форум “Шүүх хуралдааны ажиглалт” Судалгааны нэгдсэн тайлан, Н.Туяа нар,УБ., 2015, 35 дахь тал.

ДҮГНЭЛТ

Шүүхийн ажиглалтын энэ удаагийн төслийн онцлог нь зөвхөн орон нутгийн шүүхийг сонгон авч ажигласан явдал бөгөөд ингэснээр шүүхүүдийн үйл ажиллагааг харьцуулан дүгнэхэд дөхөмтэй болсон гэж үзэж байна. Өмнө хэрэгжүүлсэн 2010, 2015 оны ажиглалтыг гол төлөв өвлийн улиралд хэрэгжүүлж байсан бол энэ удаад зуны улиралд хэрэгжүүлснээрээ мөн онцлогтой болсон гэж үзэж байна.

Шүүхийн захиргааны хувьд маш өндөр үнэлгээтэй буюу 2010 оны үед байсан дутагдлууд бүрэн шийдэгдсэн байдал харагдаж байна. Үүнд шүүхийн байрны нөхцөл байдал, тоног төхөөрөмжийн ажиллагаа, шүүхийн захиргааны ажилтны харилцаа хандлага зэрэг үзүүлэлтийг авч үзлээ.

Ажиглалтын үр дүнг өмнөх төслүүдтэй харьцуулахад Шүүгчийн зүгээс оролцогчдод эрх үүргийг тайлбарлах, шүүхийн хэлэлцүүлэгт төвлөрч ажиллах байдал, шүүх хуралдааны нээлттэй байдал сайжирсан үзүүлэлттэй байгаа хэдий ч шүүхийн ажиглалт явагдаж байгаа гэсэн утгаар ердийн байдлаас

илүү нээлттэй, ажил хэрэгч байсан байх магадлалтайг үгүйсгэхгүй. Учир нь ажиглагчид шүүхийн ажиглалтын төсөл хэргжүүлж байна гэж мэдэгдсэн учраас тэдний хувьд шүүх хуралд нээлттэй оруулж байсан бол ажиглалтын эхний долоо хоногт шүүхийн ажиглагчдаас албан бичиг, зөвшөөрөл ирүүлэхийг шаардаж байсан зэргээс ийнхүү дүгнэж байна.

Шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулах нь шүүхийн үйл ажиллагааны үр нөлөөт байдалд сөргөөр нөлөөлж байна. Бидний хэрэгжүүлсэн 2010, 2015, 2017 оны шүүхийн ажиглалтад энэ үзүүлэлт ямагт өндөр хувьтай гарч байсан бөгөөд ихэнх тохиолдолд шүүх хуралдааны оролцогчдоос шалтгаалж байгааг ажиглалтын дүнгээс харж болно. Улсын яллагчаас шалтгаалсан хойшлолт 2015 оноос хойш 3 дахин буурсан байхад өмгөөлөгчөөс хамааралтай хойшлолт даруй 10 хувиар нэмэгдэж нийт хойшлолтын 62,5 хувьд нь өмгөөлөгч хурлыг хойшлуулж байгаа нь анхаарал татаж байна. Улмаар шүүх хуралдаанд өмгөөлөгчдийн оролцоог харахад улсын өмгөөлөгч болон хохирогчийн

өмгөөлөгчийн оролцоо нэмэгдсэн байгааг харж болно. Гэсэн хэдий ч улсын өмгөөлөгчийн ур чадварт эргэлзсэн, сэтгэл хангалуун биш байгаагаас шүүгдэгч өмгөөлөгчөөс татгалзсан тохиолдол гарсныг дурдах нь зүйтэй. Цаашид шүүхэд хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа өмгөөлөгчдийн мэргэжлийн ур чадвар, хариуцлага, ёс зүйн талаар Монголын хуульчдын холбоо анхаарч ажиллах шаардлагатай байна.

Е

ХАВСРАЛТ

Шүүх хуралдааны ажиглалтын хуудас

Ажиглагчдын мэдээлэл:

1. _____
2. _____

А. Шүүх хуралдааны ерөнхий мэдээлэл:

1. Шүүхийн ажиглалтын огноо: _____
2. Шүүх хуралдааны хуваарьт цаг: _____
3. Шүүх хуралдаан эхэлсэн цаг: _____
4. Шүүх хуралдаан дууссан цаг: _____
5. Шүүх хуралдаан хуваарьт цагаасаа хоцорч эхэлсэн бол шалтгааныг бичнэ.

6. Шүүх хуралдаан хойшилсон эсэх: Тийм Үгүй
7. Шүүх хуралдаан хойшлогдсон бол хэнээс болж хойшлогдсон, шалтгааныг бичнэ.
 - а) шүүгч
 - б) улсын яллагч
 - в) шүүгдэгч
 - г) шүүгдэгчийн өмгөөлөгч
 - д) хохирогч
 - е) хохирогчийн өмгөөлөгч

ё) иргэдийн төлөөлөгч

з) бусад оролцогч

Шалтгаан: _____

8. Талуудаас шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлт гаргасан байдал:

а) утсаар

б) бичгээр

в) амаар

г) тодорхойгүй

9. Эрүүгийн хэргийн зүйлчлэл:

10. Шүүх бүрэлдэхүүн (доорх хариултаас сонгож тэмдэглэнэ үү):

а) Шүүгч дангаар

б) Шүүх бүрэлдэхүүн

11. Шүүх хуралдааны даргалагчийн овог, нэр: _____

Шүүгчийн овог, _____

Шүүгчийн овог, нэр _____

12. Шүүгдэгчийн талаарх мэдээлэл:

Овог, Нэр: _____

Иргэний харьяалал: _____

Овог нэр: _____

Иргэний харьяалал: _____

Овог нэр: _____

Иргэний харьяалал: _____

13. Улсын яллагчийн овог, нэр: _____

ШУДАРГА ШҮҮХИЙН СТАНДАРТ

Б. Шүүх хуралдааны нээлттэй байдал

1. Шүүх хуралдааны танхимд нэвтэрсэн байдал:

а) ямар ч саадгүй нэвтэрсэн

б) биеийн байцаалт шалгаж оруулсан

в) оруулахаас татгалзсан, шалтгаан: _____

Хэн: _____

2. Шүүх хуралдаан нээлттэй журмаар явагдсан уу? Тийм Үгүй

3. Шүүгч нээлттэй зарлагдсан шүүх хуралдааныг хаалттай явуулахаар шийдвэрлэсэн үү? Тийм Үгүй

4. Тийм бол шалтгаан: _____

5. Нээлттэй шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй бусад хүмүүсийг оруулсан уу? Тийм Үгүй
6. Үгүй бол ямар шалтгаанаар: _____
7. Нээлттэй шүүх хуралдаанд оролцоход зөвшөөрөл авсан уу? Тийм Үгүй
8. Тийм бол хэнээс?
- а) шүүгч
 - б) шүүгчийн туслах
 - в) шүүх хуралдааны нарийн бичгийн дарга
 - г) шүүхийн хуяг
 - д) шүүхийн захиргааны бусад ажилтан
9. Шүүх хуралдаанд оролцогчдын зүгээс таныг нээлттэй шүүх хуралдаанд оролцуулахаас татгалзсан уу? Тийм Үгүй
10. Тийм бол хэн:
- а) шүүгч
 - б) улсын яллагч
 - в) өмгөөлөгч
 - г) хохирогч
 - д) шүүгдэгч

В. Хараат бус, бие даасан, шударга шүүхээр шүүлгэх эрх

1. Шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах эрхийг шүүгч тайлбарлаж өгсөн үү? Тийм Үгүй
2. Доорх этгээдүүдийг татгалзан гаргах хүсэлт тавьсан уу?
- а) Даргалагч шүүгч Тийм Үгүй
 - б) Бүрэлдэхүүнд орсон шүүгч Тийм Үгүй
 - в) Бусад этгээд _____ Тийм Үгүй
3. Хэрэв тийм бол хүсэлтийг биелүүлсэн үү? Тийм _____
Үгүй _____
4. Шүүгч хэргийг алагчлалгүй шийдвэрлэсэн эсэхэд эргэлзээ төрсөн үү? Тийм Үгүй
- Тийм бол яагаад: _____
5. Шүүгдэгчийн эрх, үүргийг сануулсан эсэх: (сануулаагүй эрхийн өмнөх тоог дугуйлах)
1. Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх
 2. Яллах дүгнэлттэй танилцах
 3. Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах
 4. Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах
 5. Мэдүүлэг өгөх, өгөхөөс татгалзах
 6. Нотлох баримт гаргаж өгөх болон шалгуулах
 7. Хэргийн материалтай танилцах

8. Шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах, тэмдэглэлд засвар, өөрчлөлт оруулах хүсэлт гаргах
 9. Шүүх хуралдаанд оролцох
 10. Шүүх хуралдааны оролцогчийг татгалзан гаргах
 11. ЭБША-ны талаар гомдол гаргах
 12. Шинжээчийн дүгнэлттэй танилцах
 13. Эх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч хэлмэрч авах
 14. Шүүх хуралдаанд эцсийн үг хэлэх
 15. Шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах
 16. Өөрийн эсрэг мэдүүлэг өгөх болон гэм буруутай эсэхээ нотлох үүрэг
 17. хүлээхгүй байх
 18. Шүүхээс дуудсан цагт ирэх үүрэгтэй
 19. Шүүх хуралдааны дэгийг сахих үүрэгтэй
6. Шүүгч шүүх хуралдааны оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгсөн үү? Тийм Үгүй
 7. Яллагчийн уншиж сонгосон яллах дүгнэлт шүүгдэгчийн гардаж авсантай таарч байгааг тодруулсан уу? Тийм Үгүй
 8. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүх хуралдааны үеэр талууд идэвхтэй мэтгэлцсэн үү? Тийм Үгүй
 9. Шүүгч хэлэлцүүлгийн үеэр шүүх хуралдааны танхимыг түр орхин гарсан уу? Тийм Үгүй
 10. Шүүгчийн анхаарал төвлөрөл сайн байсан уу? Тийм Үгүй
 11. Үгүй бол: (10-р асуултад “Үгүй” гэж хариулсан бол бөглөнө)
 - а) хоорондоо ярилцах
 - б) гар утсаа ашиглах
 - в) сонин, сэтгүүл унших
 - г) бусад хэлбэрээр _____
 12. Шүүгчид зөвлөлдөх тасалгаанд шийдвэр гаргах үед зөвлөлдөх тасалгаанд өөр хүн орсон уу? Тийм Үгүй
 13. Тийм бол тодорхойлно уу? _____
- Г. Гэм буруугүйд тооцогдох, гэм бурууг хүчээр хүлээлгэхээс ангид байх, өөрийнхөө болон гэр бүлийнхээ гишүүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх**
1. Шүүгдэгчийг гэм буруутай мэтээр сэтгэгдэл төрүүлсэн, ямарваа шинж тэмдэг байсан уу?
 - а) үсийг нь хуссан
 - б) хоригдлын дүрэмт хувцас өмсүүлэх
 - в) шинж тэмдэг илрээгүй
 2. Улсын яллагчтай харьцуулахад өмгөөлөх тал хүчин чадал сул байсан уу? Тийм Үгүй

- | | | |
|--|------|------|
| 3. Улсын яллагч шүүхийн хэлэлцүүлгийн үеэр шүүгдэгчийг ёс суртахууны хувьд дорд үзэж илт буруутгаж харьцсан уу? | Тийм | Үгүй |
| 4. Шүүгч шүүхийн хэлэлцүүлгийн үеэр шүүгдэгчийг ёс суртахууны хувьд дорд үзэж, илт буруутгаж харьцсан уу? | Тийм | Үгүй |
| 5. Шүүгч шүүгдэгчид өөрийнхөө эсрэг болон гэр бүлийн гишүүнийхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг нь тайлбарлаж өгсөн үү? | Тийм | Үгүй |
| 6. Шүүгдэгч өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан уу? | Тийм | Үгүй |
| 7. Шүүгч шүүгдэгчийг асуултад хариулах үүрэггүй болон асуултад хариулахаас татгалзах нь өөрийнх нь эсрэг ашиглагдахгүй болохыг шүүгдэгчид тайлбарлаж өгсөн үү? | Тийм | Үгүй |
| 8. Шүүгч шүүгдэгчид гэм бурууг нь хүлээлгэхээр дарамталсан уу? | Тийм | Үгүй |
| 9. Шүүгч шүүх хуралдааныг хурдан дуусгахаар хичээж байсан уу? | Тийм | Үгүй |
| 10. Хэрэв тийм бол, хэрхэн, яаж? _____ | | |

Д. Нотлох баримт гаргах, үнэлүүлэх эрх

- | | | |
|---|------|------|
| 1. Шүүгдэгчийг мэдүүлэг өгч байхад нь ямар нэгэн байдлаар тасалдуулсан уу? | Тийм | Үгүй |
| 2. Хэрэв тийм бол, хэн, хэрхэн? _____ | | |
| 3. Нотлох баримтыг ямар хэлбэрээр танилцуулсан бэ? (1-ээс дээш хариулт сонгож болно) | | |
| а) Бичгийн нотлох баримтыг гаргаж үзүүлэх хэлбэрээр | | |
| б) Гэрчийн мэдүүлгийг уншиж сонгох хэлбэрээр | | |
| в) Шинжээчийн дүгнэлтийг уншиж сонгох хэлбэрээр | | |
| г) Гэрч, шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулж мэдүүлэг авах хэлбэрээр | | |
| д) Дуу, дүрс бичлэг үзүүлэх хэлбэрээр | | |
| е) Бусад хэлбэрээр _____ | | |
| 4. Дуу, дүрс бичлэгээр үзүүлэх нотлох баримтыг бүрэн, тодорхой үзүүлэх боломж, нөхцөл хангагдсан байсан уу? | Тийм | Үгүй |
| 5. Шүүх хуралдаанд яллах талын гэрч оролцсон уу? | Тийм | Үгүй |
| 6. Шүүх хуралдаанд цагаатгах талын гэрч оролцсон уу? | Тийм | Үгүй |
| 5, 6-р асуултад Үгүй гэж хариулсан бол дараагийн асуултаудыг алгасан шууд 13-р асуултад хариулна уу. | | |
| 7. Гэрчээс мэдүүлэг авах хүртэл түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргасан уу? | Тийм | Үгүй |
| 8. Шүүгч гэрчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн үү? | Тийм | Үгүй |
| 9. Шүүгч гэрчид худал мэдүүлэг өгвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг сануулсан уу? | Тийм | Үгүй |

10. Шүүх хуралдааны оролцогчдын зүгээс гэрчээс мэдүүлэг авахад сэтгэл зүйн болон бусад дарамт үзүүлсэн үү? Тийм Үгүй
11. Шүүх хуралдааны үеэр өгсөн гэрчийн мэдүүлэг мөрдөн байцаалтын явцад өгсөн мэдүүлэгтэй нь зөрсөн үү? Тийм Үгүй
12. Тийм бол зөрүүнд хэн, ямар тайлбар хийсэн бэ? _____

13. Шүүх хуралдаанд шинжээч оролцсон уу? Тийм Үгүй
13-р асуултад Үгүй гэж хариулсан бол дараагийн асуултаудыг алгасан шууд 18-р асуултад хариулна уу.
14. Шүүгч шинжээчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн үү? Тийм Үгүй
15. Шүүх хуралдааны үеэр шинжээчээс мэдүүлэг авсан уу? Тийм Үгүй
16. Тийм бол хэний санаачилгаар? _____
17. Шүүгч шүүгдэгчид шинжээчийг татгалзах эрхийг нь тайлбарлаж өгсөн үү? Тийм Үгүй
18. Шинжээчийн дүгнэлтийг хэлэлцсэний дараа нэмэлт болон дахин шинжилгээ хийлгэх асуудлаар хэргийн оролцогчид хүсэлт гаргасан уу? Тийм Үгүй
19. Нотлох баримтаа дэмжих ямар нэгэн нэмэлт санал байгаа эсэх талаар шүүгч талуудаас асуусан уу? Тийм Үгүй
20. Мөрдөн байцаалтын үеэр шүүгдэгчид сэтгэлзүйн болон бие махбодын дарамт учруулсан (албадлага), эрүү шүүлт хэрэглэсэн, хэрцгий харьцсан, заналхийлсэн, хууран мэхлэх болон бусад хууль бус арга хэрэгслийг ашигласан (доогуур нь зурах) хэмээн шүүгдэгч өмнө өгсөн мэдүүлгээсээ буцсан уу? Тийм Үгүй

Е. Талуудын тэгш байдал

1. Улсын яллагч болон өмгөөлөгч шүүх хуралдаанд тэгш эрхтэй оролцсон уу? Тийм Үгүй
 Үгүйл бол бичнэ үү. _____

2. Шүүгч шүүх хуралдааны оролцогчийн аль нэг талд давуу байдал олгосон үйлдэл гаргасан уу? Тийм Үгүй
 Тийм бол бичнэ үү. _____

3. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд улсын яллагчийн зүгээс ялын дүгнэлтийг өөрчлөх санал гаргасан уу? Тийм Үгүй

- | | | |
|---|------|------|
| 4. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд өмгөөлөгчийн зүгээс ялын асуудлаар санал гаргасан уу? | Тийм | Үгүй |
| 5. Талуудад хэлэлцүүлгийн шатанд үг хэлэхийг зөвшөөрсөн үү? | Тийм | Үгүй |
| 6. Шүүгч шүүгдэгчийг эцсийн үгээ хэлэхэд нь саад хийсэн үү? | Тийм | Үгүй |

Ж. Өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрх

- | | | |
|---|------|------|
| 1. Шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгч оролцсон уу? | Тийм | Үгүй |
| 2. Өмгөөлөгчийн овог нэр: _____
Өмгөөлөгчийн овог нэр: _____
Өмгөөлөгчийн овог нэр: _____ | | |
| 3. Шүүгдэгч өмгөөлөгчөө өөрөө сонгож, гэрээлж авсан уу? | Тийм | Үгүй |
| 4. Шүүгдэгч төрөөс томилогдсон өмгөөлөгч (улсын өмгөөлөгч) авсан уу? | Тийм | Үгүй |
| 5. Шүүх хуралдаанд хохирогч оролцсон уу? | Тийм | Үгүй |
| 6. Шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон уу? | Тийм | Үгүй |
| 7. Өмгөөлөгчийн овог нэр: _____ | | |
| 8. Шүүгч шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхээ эдлэх хүсэлтэй байхад уг эрхийг нь эдлүүлээгүй, хязгаарласан уу? | Тийм | Үгүй |
| 9. Хэрэв тийм бол тодорхойлно уу? _____ | | |
| 10. Шүүх хуралдааны үеэр шүүгдэгчийн өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчтэй харилцаж байсан харилцааны хэв маягийг тодорхойлно уу? | | |
| а) хэвийн | | |
| б) хүйтэн, дээрэнгүй | | |
| в) үл тоомсорлосон | | |
| г) огт харьцаагүй | | |
| д) мэдэхгүй | | |
| 11. Шүүх хуралдааны үеэр өмгөөлөгч шүүгдэгчтэй харилцах боломжыг тодорхойлно уу? | | |
| а) харилцах боломжтой зэрэгцэж суусан байсан | | |
| б) харилцан ярилцах боломжгүй байсан | | |
| в) харилцах боломж хязгаарлагдмал байсан | | |
| г) харилцахыг даргалагч шүүгч хориглож байсан | | |
| д) хурлын дэгд захирагдахыг шаардаж байсан | | |
| 12. Шүүгдэгч өмгөөлөгчөөсөө татгалзах хүсэлт гаргасан уу? | Тийм | Үгүй |
| Тийм бол ямар үндэслэлээр: _____ | | |
| 13. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцоходоо хэргийн материалыг хангалттай сайн судалж, танилцсан байсан уу? | Тийм | Үгүй |

14. Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо хэргийн материалыг хуулбарлаж авсан байсан уу? Тийм Үгүй
15. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд идэвхтэй мэтгэлцэж оролцсон уу? Тийм Үгүй

3. Орчуулагч, хэлмэрч авах эрх

1. Шүүх хуралдаанд орчуулагч оролцсон уу? Тийм Үгүй
Тийм бол хэний орчуулагчаар:
 а) Шүүгдэгч
 б) Хохирогч
 в) Гэрч
2. Шүүгдэгч орчуулагч/ хэлмэрч авах хүсэлт гаргасан уу? Тийм Үгүй
3. Хүсэлтийг хангасан уу? Тийм Үгүй
Ямар хэлээр: _____
4. Шүүх хуралдаанд дохионы хэлний хэлмэрч оролцсон уу? Тийм Үгүй
Тийм бол хэний хэлмэрчээр:
 а) Шүүгдэгч
 б) Хохирогч
 в) Гэрч
5. Орчуулагч, хэлмэрчийн эрх, үүргийг шүүгч тайлбарлаж өгсөн үү? Тийм Үгүй
6. Худал орчуулсан, хэлмэрчилсэн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар орчуулагч/хэлмэрчид сануулсан уу? Тийм Үгүй
7. Талуудад орчуулагч/хэлмэрчийг татгалзан гаргах эрхийг нь тайлбарлаж өгсөн үү? Тийм Үгүй
8. Хуулийн дагуу өмгөөлөгчид гардуулан өгөх ёстой, шүүхийн баримт бичгүүдийн орчуулгын бичмэл хувийг шүүх хуралдааны явцад шүүгдэгчид өгсөн үү? Тийм Үгүй

И. Шүүхийн шийдвэр

1. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны тэмдэглэлийг ямар хэлбэрээр хөтөлсөн бэ? (1-ээс дээш хариулт сонгож болно)
 а) Гараар бичиж
 б) Компьютерт шивж
 в) Аудио/ видео бичлэгээр
 г) Бусад хэлбэрээр
2. Шүүх хуралдааны үеэр шүүх хуралдааны тэмдэглэлийг үнэн зөв бичиж буй эсэхийг хянах дэлгэц байсан уу? Тийм Үгүй
3. Шүүхийн тогтоолын агуулга: (2 буюу түүнээс дээш шүүгдэгч оролцсон бол 1-ээс дээш хариултыг сонгож болно)
 а) Шүүгдэгчийг цагаатгасан

- б) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон
 в) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон боловч Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу ялыг өршөөн хэлтрүүлсэн
 г) Хавтаст хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан
 д) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч тэнссэн
 е) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч ял эдлүүлэхийг хойшлуулсан
 ё) Бусад _____
4. Шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон бол, шүүхээс оногдуулсан ялын хэмжээ нь улсын яллагчийн ялах дүгнэлтэд зааснаас ялгаатай байсан уу?
 а) Ижил ял оноосон
 б) Илүү хөнгөн ял оноосон
 в) Мэдэхгүй
5. Шүүгч шүүхийн тогтоолд давж заалдах эрхийг сануулсан уу? Тийм Үгүй
6. Шүүгч шүүхийн тогтоолыг шүүгдэгчдэд тайлбарлан ойлгуулсан уу? Тийм Үгүй
7. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүхийн тогтоол нь:
 а) Хангалттай нотлох баримтад тулгуурлаж гарсан Тийм Үгүй
 б) Хагас дутуу байдлаар үнэлж шийдвэр гарсан Тийм Үгүй
8. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон уу? Тийм Үгүй
 Оролцсон бол тэдний овог нэр: 1. _____
 2. _____
 3. _____
9. Иргэдийн төлөөлөгч дүгнэлтээ уншиж сонсгосон уу? Тийм Үгүй
10. Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулга:
 а) шүүгдэгч гэм буруутай
 б) шүүгдэгч гэм буруугүй
 в) шүүгдэгч гэм буруутай эсэх талаар тодорхой дүгнэлт гаргаагүй

К. Шүүхийн нөхцөл байдал болон шүүгч, шүүхийн ажилтнуудын харилцааны байдал

1. Шүүхийн байр нь цэвэр цэмцгэр, хүндэтгэл төрүүлэхүйц байсан уу? Тийм Үгүй
2. Шүүх хуралдааны танхим цэвэр, тохилог, хүндэтгэл төрүүлэхүйц байсан уу? Тийм Үгүй
3. Шүүх хуралдаанд оролцогчдын яриа тод сонсогдож байсан уу? Тийм Үгүй
4. Шүүх хуралдааны танхимын микрофон, чанга яригч хэвийн ажиллагаатай байсан уу? Тийм Үгүй
5. Шүүгч өмсгөлөө өмссөн байсан уу? Тийм Үгүй

6. Шүүх бүрэлдэхүүн орж ирэхэд шүүхийн танхимд байсан хүмүүс босож хүндэтгэл үзүүлсэн үү? *Тийм* *Үгүй*
7. Шүүх хуралдааны дэгийг оролцогчдод тайлбарлаж таниулсан уу? *Тийм* *Үгүй*
8. Шүүхийн танхимд журам сахиулах хуяг байсан уу? *Тийм* *Үгүй*
9. Шүүхийн журам сахиулах хуяг хуралдааныг дуустал танхимыг орхилгүй байсан уу? *Тийм* *Үгүй*
10. Шүүх хуралдааны дэг зөрчигдөж байсан уу? *Тийм* *Үгүй*
11. Тийм бол шүүгч ямар арга хэмжээ авсан бэ? (10-р асуултад Тийм гэж хариулсан бол энэ асуултыг бөглөнө)
-
12. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны бэлтгэлийг бүрэн хангасан байсан уу? *Тийм* *Үгүй*
13. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шаардлагатай техник хэрэгслийг шүүх хуралдаан эхлэхээс өмнө бэлэн болгосон байсан уу? *Тийм* *Үгүй*
14. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга албаны байдлаар хувцасласан байсан уу? *Тийм* *Үгүй*
15. Шүүх хуралдаан эхлэхэд бүх оролцогчид зохих байраа эзэлсэн байсан уу? *Тийм* *Үгүй*
16. Шүүх хуралдааны үеэр аудио видео бичлэг хийгдэж байсан уу? *Тийм* *Үгүй*
17. Шүүхийн харуул хуягийн иргэдтэй харилцах байдал таны ажигласнаар:
- Эелдэг, уриалагхан*
 - Энгийн*
 - Хөндий хүйтэн*
 - Бүдүүлэг, дээрэнгүй*
 - Ялгамжтай*
 - Мэдэхгүй*
18. Шүүхийн нарийн бичгийн даргын харилцаа таны ажигласнаар:
- Эелдэг, уриалагхан*
 - Энгийн*
 - Хөндий хүйтэн*
 - Бүдүүлэг, дээрэнгүй*
 - Ялгамжтай*
 - Мэдэхгүй*
19. Шүүхийн дэг сахиулах хуягийн харилцаа таны ажигласнаар:
- Эелдэг, уриалагхан*
 - Энгийн*
 - Хөндий хүйтэн*
 - Бүдүүлэг, дээрэнгүй*

- д) Ялгамжтай
- е) Мэдэхгүй

20. Шүүгч шүүх хуралдааны оролцогч нартай харилцах байдал таны ажигласнаар:

- а) Эелдэг, уриалагхан
- б) Энгийн
- в) Хөндий хүйтэн
- г) Бүдүүлэг, дээрэнгүй
- д) Ялгамжтай
- е) Мэдэхгүй

Огноо/ Газар: **Ажиглагчийн гарын үсэг:** **Ажиглагчийн гарын үсэг:**

(Бусад анхаарал татсан, мэдээлбэл зохих асуудлыг үлдсэн зайнд бичиж хуудас тус бүрт асуулгын хуудасны кодыг тавьж гарын үсэг зурж баталгаажуулна.)

ШҮҮХИЙН АЖИГЛАГЧИД

Булган

Х.Нарангэрэл	Гэрэлт ирээдүйн оршихуй
Ч.Ариун	Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан
Г.Норжмаа	Булганы мэдээ сонин

Дархан-Уул

Б.Сүндэрмаа	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын Дархан салбар
Ц.Оюунчимэг	Аз жаргалын эрэлд
О.Хишигсүрэн	Мэдээллийн Орхон XXI зуун төв

Дорнод

П.Алтаннавч	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний Дорнод аймгийн салбар
Д.Мөнхзаяа	Улс төрийн боловсролын академийн Дорнод салбар
Д.Ганцогт	Улс төрийн боловсролын академийн Дорнод салбар

Завхан

З.Цэрэндулам	Завхан аймгийн Ахмад мэргэжилтний холбоо
М.Пүрэвжүгдэр	Өсвөр үеийн өөртөө туслах төв
Г.Цэцэгээ	Эмнести Интернэшнлийн Завхан аймгийн албан бус бүлэг

Орхон

Б.Аюуш	Төр-Иргэн Түншлэл
Б.Батжаргал	Орхон аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг
Б.Батцэцэг	Эрдэнэт хүмүүний эв нэгдэл
Д.Жавхланпүрэв	Ариун хэлхээ

Өвөрхангай

Л.Төмөртоогоо	Эх нутаг хөгжил төв
Ч.Ганцэцэг	Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сан ТББ-ын Өвөрхангай аймаг дахь салбар
Ц.Оюунтунгалаг	Өвөрхангай аймгийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн холбоо
Д.Цэвэлсүрэн	Хүчирхэг үндэстэн

Өмнөговь

С.Энэбиш	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний Өмнөговь аймгийн салбар
Д.Давааням	Говийн хөгжлийн зуун

Г.Нарангоо Иргэний нийгмийн байгууллагын сургагч багш
Г.Цэцэгдэлгэр Өмнөговь Аймгийн ахмадын хороо

Увс

Р.Алтанцэцэг Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөний Увс аймгийн салбар
В.Төөрүүл Өсвөр үе ирээдүй Увс төв
Б.Батцэцэг Нийгмийн ардчилал монголын эмэгтэйчүүдийн холбоо

Хөвсгөл

Ж.Бямбажав Сүүн тахилт
С.Лонжид Мөрөн сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо
Г.Чимгээ Сайн засаглалыг дэмжигч иргэдийн холбоо

Хэнтий

Т.Эрдэнэбаатар Хэнтий аймгийн Ажил олгогч эздийн холбоо
Д.Аззаяа Хэнтий аймгийн Ажил олгогч эздийн холбоо
Ч.Хос-Эрдэнэ Хэнтий аймгийн Скаутын зөвлөл
О.Баттогтох Хэрлэн тоонот Эко